




ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН СУРГУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ӨРӨМДЛӨГИЙН ХОЛБОО



ӨРӨМДЛӨГ DRILLING 2021

Эрдэм шинжилгээ, онол практикийн XXIII хурал
Scientific and theoretical & practical conference #23



Улаанбаатар хот
2021 он

ӨРӨМДЛӨГ-2021 (DRILLING-2021)

Эрдэм шинжилгээ, онол практикийн XXIII хурлын илтгэлүүдийн эмхэтгэл-e-version

2021 № 1/23

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг өрөмдлөгийн эрдэм шинжилгээ, онол-практикийн бага хурлын энэхүү эмхэтгэлд ашигт малтмалын судалгаа, нөөцийг тогтооход өрөмдлөгийн үүрэг, ач холбогдол, өрөмдлөгийн нөхцөл, тоног төхөөрөмж, технологи-менежментийн талаар илтгэл, өгүүлүүд оров.

Энэхүү хурлын эмхэтгэлийг дэлхий нийтийг хамраад байгаа цар тахлын улмаас хэвлэмэл бус цахим хэлбэрээр гаргалаа.

Номын хур арвин, өрмийн хушуу хурц байх болтугай

ШУТИС, ГУУС, Газрын тос, өрөмдлөгийн салбар
Монгол Улсын Өрөмдлөгийн Холбоо

Эрхлэх зөвлөл:

Ерөнхий редактор:

Техникийн ухааны доктор (PhD), профессор Ж.Цэвээнжав

Редактор:

Техникийн ухааны доктор (PhD), профессор Л.Төвхөө

Техникийн ухааны доктор (PhD), дэд профессор Д.Ундармаа

Гишүүд:

Шинжлэх ухааны доктор (ScD), профессор Л.Дүгэржав

Техникийн ухааны доктор (PhD), дэд профессор М.Наранбат

Техникийн ухааны доктор (PhD) Д.Батмөнх

Хэвлэлд бэлтгэсэн:

Магистр С.Жавхлантөгс

Магистр Д.Ууганбаяр

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН СУРГУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ӨРӨМДЛӨГИЙН ХОЛБОО

ӨРӨМДЛӨГ-2021

DRILLING-2021

№1/23

УЛААНБААТАР ХОТ
2021 он

ГАРЧИГ

I. ЕРӨНХИЙ АСУУДЛУУД

- 1.1. ДЭЛХИЙ ХЭРХЭН БҮТЭЭГДСЭН ВЭ-АЛТ 5
Л.Лхагвасүрэн
- 1.2. МЭРГЭШСЭН МЭРГЭЖИЛТНИЙ СУРГАЛТ, ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ, ЭРХИЙН СУНГАЛТ (Өрөмдлөг, Газрын тосны инженерийн мэргэжлийн жишээгээр) 8
Ж.Цэвээнжав, А.Баасанжаргал, Д.Ундармаа
- 1.3. АШИГТ МАЛТМАЛЫН ОРДЫН СУДАЛГАА, НӨӨЦИЙН ТООЦООНД ӨРӨМДЛӨГИЙН ҮҮРЭГ, АЧ ХОЛБОГДОЛ 10
Ж.Цэвээнжав, М.Наранбат, Д.Түвшинбаяр

II. ӨРӨМДЛӨГИЙН НӨХЦӨЛ, ТЕХНОЛОГИ

- 2.1. БАЯНГОЛЫН ТӨМРИЙН ОРДЫН ЧУЛУУЛГИЙН ӨРӨМДӨГДӨХ ЗЭРГИЙГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА, ҮР ДҮН 14
Д.Ундармаа, Ж.Цэвээнжав, Л.Төвхөө, Ц.Удвалхорлоо, Д.Ууганбаяр Д.Сувд-Эрдэнэ, Б.Сувд-Эрдэнэ
- 2.2. ЭРДЭНЭТИЙН-ОВОО ОРДЫН ӨРӨМДЛӨГИЙН УГААЛГЫН ШИНГЭНИЙ ШИНЖ ЧАНАРЫН СУДАЛГАА 22
Д.Ундармаа, Ж.Цэвээнжав, Т.Майнбаяр, Б.Эрдэнэбаяр
- 2.3. ДАЛД УУРХАЙН ӨРӨМДЛӨГИЙН УГААЛГЫН ШИНГЭНИЙ СУДАЛГАА 25
Д.Ундармаа, З.Болд-Эрдэнэ, Ж.Бат

III. ӨРӨМДЛӨГИЙН ТЕХНИК

- 3.1. MEASUREMENT, PREDICTION, AND MODELING OF BIT WEAR DURING DRILLING OPERATIONS 31
Mehmet Capik, Batnyam Batmunkh
- 3.2. АНАЛИЗ И ВЫБОР КОНСТРУКТИВНЫХ ЭЛЕМЕНТОВ СЪЕМНОГО ПОРОДОРАЗРУШАЮЩЕГО ИНСТРУМЕНТА ДЛЯ БУРЕНИЯ С ХОДОВОЙ КОЛОННОЙ 44
В.Г. Гореликов, Л.А.Басова, Баатархуу Гантулга, А.М. Успехов

IV. БУСАД

- 4.1 АВДАЙ БАГШТАЙГАА АЖИЛЛАСАН ОН ЖИЛҮҮД 48
(Гэгээлэг сайхан дурсамж)
Ж.Цэвээнжав

I. ЕРӨНХИЙ АСУУДЛУУД

ДЭЛХИЙ ХЭРХЭН БҮТЭЭГДСЭН ВЭ-АЛТ

Л.Лхагвасүрэн
Монгол улс, Улаанбаатар, “Дун-Эрдэнэ-Улз” ХХК
lhagva_0804@yahoo.com

Дэлхий дээрх амьдрал байгалийн хөгжлийн явцад үүссэн байдаг. Одоогоос 4.5 тэрбум жилийн өмнө нарны аймаг хэмээх оддын тогтолцоонд халуун хий, солирын тоосноос бүрдсэн бөөгнөрөл үүсч тэр нь улам томорч хатуурснаар сансрын нэгэн биет дэлхийн гараг бүрэлдэж, улмаар 0.5 тэрбум жилийн дараа амьдрал үүсч хөгжсөн гэдэг.

(Б.Лайхансүрэн “Эрдэмд зорих зам” номноос 149-р хуудас)

I. УДИРТГАЛ

Ийнхүү дэлхийг бүтээлцсэн “Алт” хэмээх ер бусын гайхамшигтай, уян хатан, дахин давтагдашгүй, хамгийн үнэтэй, мөнхийн хэрэглээтэй, элэгдэж дуусдаггүй өвөрмөц шинж чанартай онцгой металл.

Энэхүү ер бусын металл манай дэлхий үүсэхээс бүр өмнө задгай сансарт бий болсон гэдгийг физикийн эрдэмтэд нотолсон юм.

Одоогоос 5 тэрбум жилийн тэртээ алт болон бусад хүнд металлууд шинэ од гэж нэрлэгддэг унтарч буй аварга том одыг дэлбэрч байх үеэр бий болсон ажээ.

Тэнд шинэ од дэлбэрэхэд цохилтын долгионд нь дайгдсан алтны өчүүхэн хэсгүүд 30 км/сек хурдтайгаар нарны аймгийн эрхсүүдэд тархсан.

Нарны аймгийн гарагууд сансрын эрхсээс бүрэлдэж эхлэхэд тодорхой хэмжээний алт дэлхийн гарагийн чулуулаг дотор баригдсан байжээ.

Химийн урвалд ордоггүй алтны өчүүхэн жижиг хэсгүүд одоо болтол манай дэлхийн эрдэс чулуулгийн бүх давхаргад тун бага хэмжээгээр байдаг.

Энэ нь” Алт “тун өчүүхэн жаахан хэмжээнд оршдогт асуудлын гол нь байдаг.

Алтны анхны томоохон хуримтлал Австралийн Баруун эрэг, Африк, Перу, Канад, АНУ-ын баруун хэсэгт тархсан байдаг. (“Дэлхий хэрхэн бүтээгдсэн-Алт” шинжлэх ухааны хялбаршуулсан лекцээс)

Иймд металл ашигт малтмал болох Алтны гарал үүсэл, шилжилт хөдөлгөөн, зөөгдөл хуримтлал нь геологийн урт удаан хугацааны явцад бүрэлдэн бий болсныг геодинамик, геотектоник болон алтны

металлогений холбоо, хөгжил хөдөлгөөний онол арга зүйд тулгуурласан судалгааны өгүүллээс товчлон толилуулж байна.

II. ДАВХАРГА ЗҮЙ БА АЛТНЫ ГАРАЛ, ҮҮСЭЛ

Нэг. Геодинамик ба алтны металлогений холбоо

Геотектоник бол литосферийн плит болон доод ба дээд мантийн хөдөлгөөн тэдгээрийн хөгжлийн явцад дэлхийн гадна талын юуны түрүүнд цардаст бүрхүүлд илэрч байгаа магмын чулуулгийн найрлага, гарал үүсэл, нас, орон зай зэргийг судалдагийн зэрэгцээ тэдгээрийн өгөршлийн явцад буй болсон геологийн бүрдлийг үүсгэж буй бүтэц, хэлбэр физик-химийн шинж чанарыг бүхэлд нь судалдаг шинжлэх ухаан юм.

Судалгааны гол аргууд бол чулуулгийн найрлага, нас болон үүсэж байгаа структур, фац, формацийн шинжилгээ тэдгээрийн зузаан эзэлхүүн зэрэг дээр үндэслэж байснаас гадна геофизик, геохими ба өрөмдлөгийн аргууд бас багтана.

Геодинамик нь өөр хоорондоо цаг хугацаа гарал үүсэл, орон зайны хувьд учир шалтгааны харилцан холбоотой атмосфер царцдасаас аваад дэлхийн цөм хүртэл орон зайд явагдаж буй бүх хүчний нөлөөгөөр литосферт, улмаар царцдаст илэрч байгаа тектоникийн явцууд тэдгээрийн үүсэл хөгжлийн байдал, хөдөлгөөн түүний чиглэл хүчний зүй тогтлыг судалдаг шинжлэх ухаан юм.

Манай улсын нутаг дэвсгэрт хожуу протерзойгоос юрыг хүртэл хэлбэржсэн атираат структурууд Палеоази, Монгол-Агнуур, Неоазий, Палеотетис дөрвөн далайн суурин дээр хэлбэржиж байсан болохыг нэг талаас өөр өөр насны офиолит, офирекс зэрэг далайн плитийн үлдэц болон нөгөө талаас тасралтгүй ялгарсан найрлагатай вулканит ба тэдэнтэй нэгэн эвшлийг үүсгэдэг мөн тийм найрлагатай интрузив бүрдлүүд илэрхийлж байгаа юм.

Геодинамикийн явцууд бол тунамал ба магмын чулуулгийн найрлага, нас, газрын гадаргад үүсгэж байгаа морфологи структурын төрөл, тэдгээрийн гүний тогтоц зэрэг нь мантид явагдаж байгаа физик химийн нөхцөлтэй салшгүй холбоотой байдгийг үнэн зөвөөр тайлбарлахад чиглэгдэж байгаа юм.

Тодруулга: Судалгаанаас үзэхэд хожуу девоны граниотиодтай холбоотой Оюу-Толгой, Цагаан – Суврага зэрэг ордууд нь үйлдвэрлэлийн ач холбогдолтой том ордуудыг үүсгэсэн, харин карбон гранидиодтой холбоотой ордууд нь өнөөгийн түвшинд томоохон ордуудыг үүсгээгүй байгаа нь харагддаг. Хожуу ордовикийн үед Төв Монголын массивын зүүн хажууг даган хожуу каледонын хэмээх томоохон орогенез явагдсан нь Палеоазийн далайгаас Монгол–Агнуур гэж нэрлэсэн шинэ далайн сав тусгаарлагдах нөхцөл бий болжээ.

Геодинамикийн явцууд нь хэд хэдэн учир шалтгааны нөлөөнд байдаг бөгөөд хамгийн түрүүнд түүний хүрээлж байгаа далай тэнгист болж тектоникийн хөдөлгөөний нөлөөнд тэлэлтийн структур болох рифтийн бүс үүснэ.

Хөгжлийн энэ үеийн явцад никель (Ni), цагаан алт (Pt), алт (Au), хүхэр (S), кобальт (Co) зэрэг хүнд элементүүд нь гадаад цөм рүү живнэ. Хөнгөн хэсэг нь өндөр температурт халж дээш нэвчсээр халуун цэгийн хэлбэрээр дэлхийн гадаргад илэрнэ.

Тодруулга: Энэ үед нумын арын (Өврийн хотгор) далай тэнгисийн захаар доод моласаар дүүрсэн Таван –Толгой зэрэг нүүрс агуулсан тэнгис эх газар ээлжилсэн горимтой царцдастай структурын хэмжээнд олон дахин давтагдсан нумын ар өврийн Боумын мөчлөг бүхий Ноён сумын хотгор луугаа адил карбон пермийн заагийн терриген – турбидит хурдсаар дүүрсэн хотгорууд үүснэ.

Хагарлууд бол далай тэнгисийн савын доош суух болон эх газарт ч гэсэн буурсан даралттай бараг бүх структурын хил зааг болоод зогсохгүй мантиас царцдас руу нэвчиж буй янз бүрийн найрлагатай гидротермаль, эпитеpmаль уусмалын нэвчих, өгсөх зам орон зай суваг нь болоод зогсохгүй магмын гаралтай бараг бүх хүдэржилт илрэл, ордуудын дамжих гол орчин нь болно.

Хагарал бол ашигт малтмалын ордуудыг илрүүлэх эрлийн ажлын гол шалгууруудын нэг байдаг.

Хагарал бол дэлхийн геологийн хөгжлийн аль ч цаг үед үүсэж байсан структур юм. Монгол - Агнуурын тэнгисийн ижил нэртэй хагарлын салбар болох Ононгийн хагарлын бүсийн дагуу баруун урдаас зүүн хойш ухарсаар хожуу перм- триас- юрын хөгжлийн үед түүний нөлөө Дөч, Улз голуудын дүүрэгт төвлөрөх болсон байна. Ононгийн хагарлын бүсэд улсын хилийн дагуу “Хил” орчмын нэртэй гранидиорит- габбриодын томоохон массив судлагдсан байдгаас гадна уг хагарлыг бүсийн дагуу сүбдиалцаж байсан, плитийн орой дээр протерозойн настай Эрээн давааны өргөгдлийн хэмжээнд өндөр нэвчилтийн бүсийн дагуу 126-146 сая жилийн настай

метаморф чулуулагтай аажим шилжилттэй гранитиодын жижиг биетүүд илэрсэн байдаг.

Дорнод-Монголд хожуу триассаас түрүү цэрд хүртэл хожуу юрад Монгол-Агнуурын, карбоны эцэст Өмнөд – Монголын далайнууд хаагдаж байсан нь тектоникийн хүч буурахад нөлөөлсөн бас нэгэн хүчин зүйл болж байсан бололтой.

Дорнод-Монголын ба Өвөр Монголын доод цэрдийн рифтийн шүтлэг базальт нь мантийн гаралтай байж болох талаар (Xu Xuan. Wu Taiwan) баталсан байдаг.

Зүүн хойд Монголын мезопротерозой хавтангийн хэмжээнд мезозойд явагдсан рифтогенез уран, алт ховор металл ба ховор элементийн хүдэржилтийг дагуулсан нь Сулинхээрийн бүсэд болсон коллизийн резонансын дамжих хүчтэй холбон тайлбарлагддаг.

Эх газрын хавтангийн тухайд Дорнод- Монголын нутаг дэвсгэрт гүехэн усны голдуу хөх ногоон зааг археоцатаар нас нь тогтоогдсон неопротерозой – түрүү палеозойн, мөн хөндий хэвэлтэн брахиподын үлдвэртэй дунд палеозойн терриген карбонат ба баруун Монголын триас, цэрдийн настай их газрын бага зузаантай гүехэн усны терриген хурдсаар хучигдсан хавтангийн структурууд хөгжиж байжээ.

Ийнхүү нэг талаас хожуу цэрдээс зүүн хойд Монголд Монгол-Агнуурын далай хаагдаж нөгөө талаас Дорнод – Монголд рифтийн тогтолцооны идэвхжилт буурч байхдаа давхцаад Өмнөд ба Зүүн Өмнөд Монголд эпиерциний Говийн хавтангийн хөгжил эхэлсэн байна.

Тодруулга: Алтны шижирмэг ордуудын шилжилт хөдөлгөөн, зөөгдөл хуримтлал нь Монгол-Агнуурын (Хангай –Хэнтийн) далайн үйл явцтай холбоотой.

Монгол –Агнуурын далайн ордовикийн 2- р хагас хүртэл Палео азийн далайн нэгэн хэсэг байгаад түүнээс хойш хожуу ордовикийн орогенезээр өргөгдсөн. Үндсэндээ хожуу ордовикаас эхлээд Хангай Хэнтийн бүсийн гадна талаар Төв-Монголын массив руугаа шаантагласан Баян-Хонгор, Хар-Хорин, Хойд Өмнөд Хэнтий болон Ононгийн дүүрэгт цахиурлаг чулуулгийн үетэй элсжин – занарын ба тунамал вулканоген чулуулгийн зузаалаг нилээд өргөн тархсан байна.

Монгол –Агнуурын далай таван зуу гаруй сая жил үргэлжлэн хөгжиж тус улсын нутаг дэвсгэрт хожуу каледоны, хожуу герциний, индосиний ба киммерийн хэмээх дөрвөн удаагийн сүбдукц – аккрец, коллизын явц болж байсан ажээ.

Неоазийн далай цаг хугацааны хувьд палеоазийн далайн дунд палеозойн үед нээгдсэн үргэлжлэл байж болох Өмнөд-Монголын далайн савыг Неоазийн далай гэж нэрлэсэн болно.

ДҮГНЭЛТ:

Аливаа ашигт малтмалын металлогенийн зүй тогтлыг геодинамикийн хөгжлийн мөчлөгтэй холбон судлах нь нэг талаас хэтийн төлөв бүхий эрлийн

талбайг ялгахад гадна тухайн геодинамикийн байдлыг хэрхэн зөв тодорхойлсныг бас харилцан шалгаж болох судалгааны сонирхолтой арга болох нь харагдлаа. Ингэж чадвал ашигт малтмалыг илрүүлэх геодинамик ба металлогений зүй тогтлыг тодорхойлдог эрлийн шалгууруудыг улам оновчтой болгох боломжтой.

Пермээс эхлээд Дорнод – Монголын эх газрын хөгжилд хожуу триасс – түрүү юра ба хожуу юрын ба Монгол-Агнуурын далайн гурван удаагийн эх газрын идэвхтэй захын ба нумын арын деструкцын бүсийн болон хожуу юраас түрүү цэрдийг дуустал Дорнод ба Зүүн Хойд Монголд бий болсон плюмийн урьтал болсон өргөгдлийн орой дээр үүссэн рифтийн хөгжил давхцаж Дорнод-Монголын эх газрын хөгжлийг улам нийлмэл болгосон.

Энэ үйл явцуудтай холбоотой Дорнод-Монголын эпитеpmал гаралтай цагаан тугалга, вольфрам, алт, хөнгөн цагаан, цайр, хар тугалга, хайлуур жонш, хүнцэл, бор, түүний дотор ураны хүдэржилт чухал байр суурь эзэлдэг.

НОМ ЗҮЙ

- [1] О.Гэрэл Монголын Геологи ба ашигт малтмал “Интрузив чулуулаг” УБ хот 2012.
- [2] Ж.Лхамсүрэн “Монголын Геологи ба ашигт малтмал” Метал ашигт малтмал” 2012
- [3] Ж.Бямба., Ю.Б.Миронов., Г.Жамсрандорж “Монголын геодинамик ба ураны металлогени” УБ хот 2018 он
- [4] Ж.Бямба., Ж.Бадамгарав., А.Баясгалан нар 2012 он. Төв Монголын атираат муж. Литосферийн плит тектоник.
- [5] Ж.Бямба., Б.Тамир 2009 он. Дөч голын хожуу палеолзойн-түрүү мезозойн субдукц-аккрецын бүрдэл.
- [6] О.Төмөртоогоо 2006 он Монгол орны прокембрий, стратиграфи, тектоник ба палеогеодинамик. Эрдэм шинжилгээний бүтээл №16. х18-46
- [7] Г.Ээнжин., В.В.Ярмолюк., А.М.Козловский., Ч.Нармандах нар 2017 он Дорнод-Монголын галт уулын рифтийн структур. Хайгуулчин №57 х43-45
- [8] Ж.Бямба Монголын Геологи ба ашигт малтмал “Стратиграфи” 2012 он
- [9] Р.Барсболд Монголын Геологи ба ашигт малтмал “Палеонтологи” 2012 он
- [10] З.Балжинням” Петрографи” 2007 он
- [11] Б.Лайхансүрэн “Эрдэмд зорих зам” 2020 он
- [12] Б.Лайхансүрэн “Уул уурхайн судлал” 2015 он
- [13] Г.Ухнаа., Г.Дэжидмаа., О.Ганцэцэг “Алт” ордын геологи эрэл хайгуул. 2017 он
- [14] Г.Дэжидмаа Геохимические особенности золоторудного поля Бороо в Монголии / Автореферат диссертации ученой степени кандидата геологи-минералогических наук. Новосибирск. 1985. 16с
- [15] Г.Дэжидмаа “Алтын ордууд” Монголын геологи ба ашигт малтмал/хариуцсан Ж/Лхамсүрэн/ УБ хот 2012 х215-264
- [16] Л.Мягмар., Л.Баасандолгор “Алтан цагаан овоогийн алт холимог металлын орд. Хайгуулчин. №46. 2012он х111-121.

- [17] Т.Семейхан “Алтын шижирмэгэн ордууд” 2013 он
- [18] Y.Yorozu, M. Hirano, K. Oka, and Y. Tagawa, “Electron spectroscopy studies on magneto-optical media and plastic substrate interface,” IEEE Transl. J. Magn. Japan, vol. 2, pp. 740–741, August 1987 [Digests 9th Annual Conf. Magnetism Japan, p. 301, 1982].
- [19] Г.Ухнаа., Г.Дэжидмаа., О.Ганцэцэг “Алт” ордын геологи эрэл хайгуул. 2017 он
- [20] Г.Дэжидмаа Геохимические особенности золоторудного поля Бороо в Монголии / Автореферат диссертации ученой степени кандидата геологи-минералогических наук. Новосибирск. 1985. 16с
- [21] Г.Дэжидмаа “Алтын ордууд” Монголын геологи ба ашигт малтмал., УБ хот 2012 х215-264
- [22] Л.Мягмар., Л.Баасандолгор “Алтан цагаан овоогийн алт холимог металлын орд. Хайгуулчин. №46. 2012он х111-121.
- [23] Т.Семейхан “Алтын шижирмэгэн ордууд” 2013 он.
- [24] I. S. Jacobs and C. P. Bean, “Fine particles, thin films and exchange anisotropy,” in Magnetism, vol. III, G. T. Rado and H. Suhl, Eds. New York: Academic, 1963, pp. 271–350.
- [25] K. Elissa, “Title of paper if known,” unpublished.
- [26] R. Nicole, “Title of paper with only first word capitalized,” J. Name Stand. Abbrev., in press.
- [27] Y. Yorozu, M. Hirano, K. Oka, and Y. Tagawa, “Electron spectroscopy studies on magneto-optical media and plastic substrate interface,” IEEE Transl. J. Magn. Japan, vol. 2, pp. 740–741, August 1987 [Digests 9th Annual Conf. Magnetism Japan, p. 301, 1982]. Y. Yorozu, M. Hirano, K. Oka, and Y. Tagawa, “Electron spectroscopy studies on magneto-optical media and plastic substrate interface,” IEEE Transl. J. Magn. Japan, vol. 2, pp. 740–741, August 1987 [Digests 9th Annual Conf. Magnetism Japan, p. 301, 1982].

МЭРГЭШСЭН МЭРГЭЖИЛТНИЙ СУРГАЛТ, ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ, ЭРХИЙН СУНГАЛТ (Өрөмдлөг, Газрын тосны инженерийн мэргэжлийн жишээгээр)

Ж.Цэвээнжав^{1,2,3}, А.Баасанжаргал^{1,3}, Д.Ундармаа^{1,2}

¹Монгол улс, Улаанбаатар, ШУТИС Геологи, уул уурхайн сургууль, Газрын тос, өрөмдлөгийн салбар

² Монгол улс, Улаанбаатар, Монгол Улсын Өрөмдлөгийн холбоо

³ Монгол улс, Улаанбаатар, Монголын Газрын тосны инженерүүдийн нийгэмлэг
btseven2003@yahoo.com, baaskanil@yahoo.com, undarmaad1976@yahoo.com

Хураангуй— Мэргэшсэн мэргэжилтний сургалт, гэрчилгээжүүлэлт, эрхийн сунгалтын асуудлыг инженер-технологийн чиглэлийн, тухайлбал, Өрөмдлөгийн (Drilling Engineer), Газрын тосны (Petroleum Engineer) Мэргэшсэн ба Зөвлөх инженерийн жишээгээр авч үзэж, судлаж, өнөөгийн байдал, тулгамдаж байгаа асуудлууд, цаашдын чиг хандлагын талаар санал дүгнэлт, зөвлөмжийг энэхүү өгүүлэлд тусгав.

I. УДИРТГАЛ

Нэг. Асуудал шийдэгдэж ирсэн замнал

Манай улс зах зээлийн эдийн засагт шилжиж, аль ч салбарт хөрөнгө оруулалт татах, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, бүтээн босголт хийхэд энэ чиглэлийн технологи-менежментийн хөтөлбөр, төслүүдийг боловсруулах, хяналт тавих, батлах, шинжээч хийх, шүүмж бичих, хэрэгжүүлэхэд Мэргэшсэн мэргэжилтнүүд (Qualified Person)-ийн хэрэгцээ шаардлага гарч Эрдэс баялаг (Геологи-хайгуулын, Уул уурхайн, Газрын тосны)-ийн салбарт гэхэд эхлээд УУЯ (одоогийн УУХҮЯ), ШУТИС-ийн ГУУС-ийн хамтын ажиллагаагаар, Геологи-хайгуулын (Г.Ухнаа, эдүгээ Гавъяат багш), доктор П.Нарантуяа), Уул уурхайн (Ц.Нанзадын, эдүгээ Академич; доктор Д.Гэрэлт-од), Газрын тосны (профессор Ж.Цэвээнжав, доктор А.Баасанжаргал) сургалт-судалгаа-мэдээллийн төвүүдээр зохион байгуулагдаж явагддаг байв. Гэтэл Мэргэшсэн мэргэжилтний сургалт-гэрчилгээжүүлэлт-эрхийн сургалтыг Мэргэжлийн төрийн бус байгууллага (ТББ)-д нь шилжүүлнэ гэж шийд гараад Геологи-уул уурхайн мэргэшсэн институт (ГУУМИ) гэдэг хувийн, хувьсгалын, мэргэжлийн аль нь болох нь тодорхойгүй, анги танхимгүй, байнгын багшгүй, татвар хураамж л харин байнга шаарддаг, авдаг бололтой байгууллага гарч ирж, хэвийн явж байсан үйл ажиллагааг олон улсын түвшний Мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэнэ гэж лоозогноод үндэсний ч зогсонги, олон улсын түвшний ч угаасаа бүтээгүй. Харин Газрын тосны чиглэлээр 2015 оноос УУХҮЯ, ШУТИС-ГУУС, МГТИН-ийн хамтарсан Зөвлөл, түүний ажлын алба болох ШУТИС-ийн Эрдмийн Зөвлөлийн шийдвэр, Ректорын тушаалаар байгуулагдсан Газрын тосны сургалт-судалгаа-мэдээллийн төв (ГТССМТ)-ийн шугамаар Газрын тосны Мэргэшсэн (Мэргэшсэн, Зөвлөх) мэргэжилтний сургалт-гэрчилгээжүүлэлт маш сайн, бүр үлгэр жишээ болохоор явагдаж өдийг хүрсэн.

Хоёр. Асуудлын өнөөгийн байдал

2.1 Хууль эрх зүй.

Ашигт малтмалын тухай хуулийн 10.1.16-д “Геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журмыг батлах”, Газрын тосны тухай хуулийн 8.1.3-д “...газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох журмыг батлах” эрхийг Салбарын төрийн захиргааны төв байгууллага (одоогоор УУХҮЯ) хэрэгжүүлнэ гэж заасан байдаг.

2.2. Дүрэм журам.

Манай Эрдэс баялгийн салбарын Мэргэшсэн мэргэжилтний сургалт, гэрчилгээжүүлэлт, эрхийн сунгалт удтал гацаж, зогсонги байдалтай байсны эцэст салбарын төрийн захиргааны төв байгууллага болох УУХҮЯ-наас энэ чиглэлийн үйл ажиллагааг МЭРГЭЖЛИЙН ТББ-Д хариуцуулахаар шийдвэрлэсэн зөв зүйтэй боловч 1. бакалавр, магистр, докторыг нь хүртэл бэлтгэдэг анги танхим, эрдэмтэн багш нар, сургалтын орчинтой Их сургуулиудын оролцоог үгүйсгээгүй юмаа гэхэд журамлаагүй, 2.Мэргэшсэн мэргэжилтний сургалт-гэрчилгээжүүлэлт-эрхийн сунгалтыг тухайн Мэргэжлийн төрийн бус байгууллага (МЭРГЭЖЛИЙН ТББ)-д гэхчээд төрийн захиргааны байгууллага өөртэйгөө харилцахад амар, зөвхөн нэг цонхоор харьц гэсэн утгаар дээрхи эрхийг Мэргэжлийн ТББ-д гэхээсээ, тухайн чиглэлийн мэргэжлийн, мэргэжлийн бус, нийтийн (public), орон нутгийн (domestic), хүйсийн (gender) зэрэг янз бүрийн ТББ –ын Зөвлөл (бөөгнөрөл)-д өгсөн, энэ нь мэргэжлийн ТББ-гээр гүйцэтгүүлэх гэсэн хуулийн заалтыг зөрчсөн гэсэн үг, шалтгаан нь нэг талаас яам ажлаа хялбарчлах гэсэн, нөгөө талаас мэргэжлийн, мэргэжлийн бус ТББ-ууд сонгон шалгаруулалтанд өрсөлдөгчгүйгээр (өрсөлдөгчгүй шалгаруулалт!) ялах эрмэлзлэл байсантай холбоотой. Жишээ нь ГМХНЗ гэдэгт энэ чиглэлийн хүмүүсийн үүсгэн байгуулсан, гэхдээ яг мэргэжлийн ямар үйл

ажиллагааг явуулдаг нь тодорхойгүй, нийгэмд үйлчилдэг, нийтийн, орон нутгийн хүйсийн зэрэг ТББ-ын нэгдэл бөгөөд энд яг МЭРГЭЖЛИЙН ТББ гэвэл Монголын Геологийн, Үйлдвэрийн Геологийн, Геофизикийн, Гидрогеологийн, Өрөмдлөгийн зэрэг 5 холбоо л байгаа юм. Бид журам гарах үед Монгол улсын Өрөмдлөгийн Холбоо Өрөмдлөг (Drilling)-ийн ММ сургалт-гэрчилгээжүүлэлт-эрхийн сунгалтын сонгон шалгаруулалтанд дангаараа оролцохоор санал хүртэл дэвшүүлж байсан болно.

Гурав. ӨРӨМДЛӨГ- DRILLING мэргэжлийн ММ-ний сургалт, гэрчилгээжүүлэлт, сунгалтын талаар.

Олон улсын Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны байгууллага Юнескогийн тодорхойлолт, ангиллаар ӨРӨМДЛӨГ- DRILLING мэргэжлийг зөвхөн Геологи-хайгуулын техник хэрэгсэл мэтээр ойлгохоо больж, энэ мэргэжил, арга ухааныг Геологийн судалгаа, Ашигт малтмалын эрэл-хайгуул-нөөцийн тооцоо, Уурхайлалт олборлолт, Газрын доорхи ус, тос, хий зэрэг шингэн ба хийн ашигт малтмалыг цооногоор олборлох ашиглах, Барилга байгууламж, зам гүүр, Эрчим хүчний шугам барих зэрэг үйлдвэрлэл-технологийн олон салбарт, түүгээр ч зогсохгүй Ахуй амьдрал, Анагаах ухаанд хүртэл хамааралтай өргөн хэрэглээтэй, онцлог МЭРГЭЖИЛ гэж үзэх болсон.

Энэ үндэслэлээр Өрөмдлөгийн мэргэшсэн мэргэжилтнүүдээс зэргээ сунгуулах, ахиулах, тодруулах, талаар ирүүлсэн саналууд, холбогдох материалууд Өрөмдлөгийн Мэргэшсэн мэргэжилтнүүдийг сургах, гэрчилгээжүүлэх, эрхийн сунгалт хийх асуудлыг хариуцсан Салбар Зөвлөл болон МҮӨХ-ны Удирдах Зөвлөл нарийвчлан нухацтай хэлэлцэж, өмнө 2015 онд DE-072403, ӨРӨМДЛӨГ (DRILLING)-ийн мэргэжлээр олгогдсон Зөвлөх-6, Мэргэшсэн-12 инженерийн эрхийн сунгалтыг холбогдох журмын болзлуудыг хангасан байдлыг ӨММЗ-өөр хэлэлцэн дүгнэлт гаргаж, ГМХНЗ-ийн ММЗ-өөр дамжуулан УУХҮЯ, ШУТИС-ийн ГУУС-д танилцуулж хянуулан Гэрчилгээг шинээр хэвлэхгүйгээр хавсралтын арын сургалтын хэсэгт Монгол улсын Өрөмдлөгийн Холбооны тамга гарын үсгээр баталгаажуулахаар санал болгож байна.

Дөрөв. ГАЗРЫН ТОСНЫ ИНЖЕНЕР-PETROLEUM ENGINEER мэргэжлийн ММ-ний сургалт, гэрчилгээжүүлэлт, сунгалтын талаар.

2015 оноос хойш хобогдох хууль, дүрэм журмын хүрээнд УУХҮЯ, ШУТИС-ГУУС-МГТИН –ээс хамтран төр, их сургууль, ТББ-ын оролцоотойгоор амжилттай сайн, бүр бусад мэргэжлүүдэд үлгэр жишээ болохоор гэж үнэлэхээр энэ чиглэлийн үйл ажиллагааг хэний санаачлагаар, ямар шалтгаанаар болох нь тодорхойгүй байдлаар гэнэт УУХҮС-ын тушаалаар батлагдсан журам энэ 2021-11-22-нд гарсан. Уг журмын агуулга нь Газрын тос, уламжлалт бус газрын тосны Мэргэшсэн мэргэжилтний сургалт-гэрчилгээжүүлэлт-сунгалтыг УУХҮЯ, ШУТИС-тэй хамтран, гэхдээ зөвхөн ГТӨС-тай хамтран зохион байгуулна, МГТИН (ТББ-ын тухай Монгол улсын

хуулийн дагуу 2010 онд байгуулагдсан цагаас хойш ямар ч ашиг сонирхлын зөрчил, гаргаагүй, бизнесийн болон бусад ашиг олох чиглэлийн үйл ажиллагаа явуулаагүй, ЗӨВХӨН ГАЗРЫН ТОСНЫ МЭРГЭЖЛИЙН үйл ажиллагаа явуулж, үйлчилгээ үзүүлж ирсэн хуулийн этгээд), Газрын тосны сургалт-судалгаа-мэдээллийн төв-ГТССМТ (ШУТИС-ийн Эрдмийн Зөвлөлийн шийдвэр, Ректорын тушаалаар байгуулагдаж, 1-2 жил дутам тайлангаа өгч, бүх удирдлага-санхүүжилт нь ГУУС-ийн шугамаар явагддаг) зэргийг энэ ажилд оролцуулахгүй гэж тодруулан заасан, хууль бус гэж үзэж болохоор журам гарсан. Нэг яам салбар гэхэд л дээрхи ажлыг нэг хэсэг чиглэлээр нь Мэргэжлийн ТББ-д нь хариуцуулна гээд, нөгөө зарим чиглэлээр нь ТББ-г оролцуулахгүй гэж бүр тодруулан журамлаж ЭСРЭГ-ТЭСРЭГ-ээр заагаад манай төр засгийн бодлого, шийдвэр, засаглал үнэхээр л доголдолтой байгаа юм. Бид салбарын удирдлагыг гэхээсээ энэ ажлыг хариуцсан хүмүүс эрх ашиг, ашиг сонирхлын зөрчилтэй байж болзошгүй гэж харж, засаж залруулах хэрэгтэй гэж үзэж байгаа болно.

ДҮГНЭЛТ:

Бүхэлдээ Мэргэшсэн мэргэжилтний сургалт-гэрчилгээжүүлэлт-сунгалт үндэсний болон олон улсын хэмжээнд маш чухал ач холбогдолтой асуудал бөгөөд энд явцуурхал, эрх мэдлийн булаацалдалт, тэр дутмаа эрх ашиг, сонирхлын зөрчил гаргахгүй зөвхөн мэргэжил, шинжлэх ухаан, арга зүйн хүрээнд авч үзэж хандах хэрэгтэй гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

- [1] Ашигт малтмалын тухай хууль (шинэчилсэн найруулга), 2006-7-8
- [2] Газрын тосны тухай хууль (шинэчилсэн найруулга), 2014-7-1
- [3] Уул уурхайн сайдын 53-р тушаал, холбогдох журам, 2015-3-12

АШИГТ МАЛТМАЛЫН ОРДЫН СУДАЛГАА, НӨӨЦИЙН ТООЦООНД ӨРӨМДЛӨГИЙН ҮҮРЭГ, АЧ ХОЛБОГДОЛ

Ж.Цэвээнжав¹, М.Наранбат², Д.Түвшинбаяр³

¹Монгол улс, Улаанбаатар, ШУТИС, Геологи, уул уурхайн сургууль, Газрын тос, өрөмдлөгийн салбар

²Монгол улс, Улаанбаатар, Монгол Улсын Өрөмдлөгийн Холбоо

³Монгол улс, Эрдэнэт, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ

btseven2003@yahoo.com, naranbatbata@gmail.com,

undarmaad1976@yahoo.com, tuvshinbayar@erdenetmc.mn,

Хураангуй — Өргөн хүрээтэй, эрэлт ихтэй үйлчилгээ, үйлдвэрлэл болох Өрөмдлөг нь газрын хэвлийн гүн орших ашигт малтмалын ордын судалгаа, эрэл-хайгуул, нөөцийн тооцоонд хамгийн чухал үүрэг ач холбогдолтой байдаг. Энэ асуудлыг эх орны төдийгүй дэлхий нийтийн ач холбогдолтой Эрдэнэтийн зэс-молибдений, Оюутолгойн зэс-алтны бүлэг ордуудын жишээгээр авч үзэж, дүгнэлт хийж, санал зөвлөмж боловсруулав.



Геологийн зураглал, ашигт малтмалын ерөнхий эрэл, эрэл үнэлгээ, хайгуул, геофизик, гидрогеологийн болон сэдэвчилсэн бусад судалгаа явагдаж, энэ талаархи үр дүн, мэдээлэлд шинжилгээ дүгнэлт хийгдсэн, олон тайлан материалд тусгагдсан байдаг бол ихээхэн хөрөнгө оруулалт гарган, өндөр өртөг зардал зарцуулан, хамгийн гол нь гүнний бодит мэдээллийг бий болгосон их хэмжээний өрөмдлөгийн үр дүн, гүйцэтгэсэн үүрэг, ач холбогдлын талаар өмнө нь ч, одоо ч, тусгайлан авч үздэггүй, технологи-менежментийн тайлан мэдээ гардаггүй, өрмийн мэргэжлийнхэн Геологийн бусад мэргэжлийнхэнтэй адилхан шалгуураар Мэргэшсэн, Зөвлөх зэрэг тогтоолгодог боловч тэр мэдлэг оюун, дадлага туршлага, мэргэжил мэргэшил нь ашиглагддаггүй, ашигладаггүй, Ашигт малтмалын геологийн судалгаа, эрэл-хайгуул, нөөцийн тооцооны тайланд зохиогчдын багт оролцуулдаггүй, шинжээч, шүүмжлэгч, зөвлөгч хийлгэдэггүй учраас бид энэ асуудлыг 2 томоохон ордын өрөмдлөгийн жишээгээр дэвшүүлж, судлаж, авч үзэж байгаа болно.

Түлхүүр үг — ашигт малтмалын орд, нөөц, эрэл, хайгуул, өрөмдлөг, дээжлэлт, судалгаа)

I. ҮНДСЭН ХЭСЭГ


A. Эрдэнэтийн ордын өрөмдлөг

Орхон-Сэлэнгийн вулкан-плутоны төвийн хэсэг болох Монгол-Агнуурын тектоник колажид Эрдэнэтийн хүдрийн дүүрэгт 3 орд 23 илрэл хамаарагдах бөгөөд үүнээс нь 14 нь порфирын Cu-Mo, 13 нь граниттай холбоотой штокверк-метасоматитын зэс (Cu)-ийн төрөлд хамаарагддаг, талбайн хэмжээнд Эрдэнэтийн, Бугатын, Могойн голын, Зүйлийн голын хүдрийн зангилаануудыг ялгадаг байна (зураг-1).1.



Эрдэнэтийн овоо зэс-молибдений ордын Баруун хойд болон Төвийн хэсгийн хүдрийн биетүүдийн хайгуулын цооногийн өрөмдлөг 1965 онд эхэлсэн гэж үзэж болно. 1978 онд олборлолтын үйл ажиллагаа эхлэхийн өмнө нийт 185 орчим цооногоор 34450.1 тууш метр өрөмдлөг хийсэн байдаг. Улмаар уурхайн талбайд нэмэлт өрөмдлөгийн ажлуудыг тогтмол хийснээс 500 м-ээс дээш гүнтэй цооногийн өрөмдлөгийн ажлыг 1982-1987 (нарийвчилсан хайгуул), 2013-оноос гүнний болон чиглэлтэй (гүйцээх) өрөмдлөгийн ажил гүйцэтгэсэн. 2016-2020 онд нийт 115155.9 тууш метр өрөмдлөгийн ажил хийснээс 37793 тууш метр өрөмдлөгийг TRM XXX (JORC стандартын дагуу), 77362.9 тууш метр өрөмдлөгийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Геологи

хайгуулын экспедиц орчин үеийн арга аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн (зураг-2).



2-р зураг. Эрдэнэтэд 2016-2020 онд өрөмдсөн хайгуулын цооногуудын мэдээлэл

Гүйцээх хайгуулын ажлыг явуулахдаа өрөмдлөгийн торлолын үзүүлэлтийг ордын геологийн тогтоц ба хүдрийн эрдсүүдийн тархалтын онцлогт үндэслэн 62.5м x 62.5м, 125м x 62.5м, 125м x 125м, 125м x 250м, 250м x 250м байхаар сонгосон байдаг. Өрөмдлөгийн чиглэлийг тодорхойлоход хүдрийн биетийн хэмжээ, тэдгээрийн судлагдсан байдал, геологийн нөхцөл байдал, олборлолтын ажлын түвшин зэрэг шалтгааныг авч үзсэн. Баруун хойд хэсэгт нийт 191 цооног буюу 87099.1 т.м-ийн хэмжээтэй, дунджаар 456.0 м (73 - 1054.0 м хүртэл) гүнтэйгээр өрөмдсөн.

Төвийн хэсэгт цооногийн өрөмдлөгийн ажлыг исэлдэлтийн болон хоёрдогч сульфидын хүдрийн бүсийг тогтоох, тэдгээрийн нөөцийн хэмжээ, зэрэглэлийг ахиулахад чиглүүлсэн байдаг. 2016-2020 онуудад нийт 28056.8 т.м-ийн хэмжээтэй 85 цооног өрөмдсөн. Цооногийн гүн 80.0-989.0 м-ийн хооронд хэлбэлзэж, дунджаар 330 м байсан.


Ордын геологи, геотехник, структур болон хүдрийн биетийн тархалтын зүй тогтлыг бүрэн ойлгох үүднээс цооногуудыг хэд хэдэн чиглэлийн дагуу өрөмдсөн ба баруун урагш 210 хэмийн азимутаар нийт өрөмдлөгийн 28.2%, зүүн хойш 31 хэмийн азимутаар нийт өрөмдлөгийн 45.8%, бусад чиглэлийн дагуу нийт өрөмдлөгийн 26.0% -ийг хамруулан, харилцан адилгүй гүнтэйгээр өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэсэн.

Цооногийн амсрын хэмжилт, азимут

Цооногийн азимут, амсрын байршлыг зөв зүйтэй хэмжих нь ордын нөөцийн тооцооны ажлын үндсэн эх үүсвэр хэмжигдэхүүний нэг болно. Цооногийн амсрыг 2015 оноос өмнө маркшейдерийн теодолит багажаар тэмдэглэдэг байсан бол түүнээс хойш дифференциал GPS систем ашиглах болсон. Нийт 2016-2020 онд гүйцэтгэсэн 276 цооногийн амсрын хэмжилтийг хийсэн.

Цооногийн картотаж

2016-2020 онуудад нийт өрөмдлөгийн 85.4%-д нь цооногийн геофизикийн хэмжилтийг хийсэн. Тухайлбал: Төвийн хэсгийн 74 цооногийн 23409.3 тууш метр, Баруун хойд хэсгийн 165 цооногийн 74960.4 тууш метрт хийгдсэн байна.



3-р зураг. Хайгуулын өрөмдлөгийн цооногуудын байршлын зураг

Цооногийн кернийн баримтжуулалт

Цооногийн кернийн баримтжуулалтыг уртыг нь хэмжиж, гарцыг тогтоох, тэмдэглэгээ, фото зураг авалт хийж геологийн баримтжуулалт, дээжлэлтэнд бэлтгэх ажлууд хийгджээ.



4-р зураг. 2016-2020 оны өрөмдлөгийн кернийн дундаж гарц


Эрдэнэтийн 2016-2020 онуудын хайгуулын ажилд нийт 55 310 204 000 төгрөгийн зардал гарсны 25 959 443 000 төгрөг буюу 46.9% - ийг гүйцээх болон нөөцийн зэрэглэл ахиулах баганат өрөмдлөгт, 15 276 222 000 төгрөг буюу 27.6%-ийг геологийн нөөцийн JORC (Жорк) ангилалд шилжүүлэн баталгаажуулах өрөмдлөгт, 1 765 846 000 төгрөг буюу 3.2%-ийг хөндлөнгийн хяналтын өрөмдлөгт тус тус зарцуулж, бүхэлдээ хайгуулын нийт зардлын 78% орчмыг өрөмдлөгт зарцуулсан байна.

II. ОЮУТОЛГОЙН ӨРӨМДЛӨГ

Оюу толгойн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд БУ-аас 3Х чигт сунасан 13 км урт, 4 км өргөнтэй хүдэржилтийн бүсэд орших Оюу толгойн бүлэг ордод Херуга, Оюут болон Хюго Дамметт ордууд багтана. Оюу Толгой ХХК нь Оюу толгой,

Жавхлант, Шивээ толгой нэртэй ашиглалтын тусгай зөвшөөрөлт талбайнуудын хэмжээнд хийгдсэн хайгуулын ажлын үр дүн, түүнд тулгуурлан тооцоолсон геологийн нөөц, баялгийг тухайн үед мөрдөгдөж байсан Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох дүрэм, журмын дагуу 2009 болон 2014 онуудад тайлагнаж Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байдаг. Судалгааны энэ шатанд уг ордод олон улсын хэмжээнд хувьцаа гарган, хөрөнгө оруулалтыг олж, асар их хэмжээний хайгуулын баганат өрөмдлөгийг явуулж, дэлхийд хоёрхон байдаг, Австрали улсад үйлдвэрлэгдсэн, хатуу чулуулагтай ашигт малтмалын үндсэн ордод 5000м хүртэл өрөмдөх хүчин чадалтай ЮДР (UDR-Universal Drilling Rig)-5000 болон UDR-1500, UDR-1000 өрмийн төхөөрөмжүүдээр геологийн судалгаа, эрэл-хайгуулын зорилгоор 2000-2500м хүртэл гүн хүртэл өрөмдөж, 1000-1500м, түүнээс ч илүү гүнд, гүний магмын цацалтаар үүссэн порфирын гаралтай өндөр агуулгатай зэс-алтны хүдэржилтийг тогтоож, 2009 оны байдлаар 44 сая тонн цэвэр зэс (pure cooper), 1938 тонн алт (gold)-ны нөөцийг тогтоож, улсын эрдэс баялгийн санд бүртгүүлсэн болно.

Оюутолгойн бүлэг ордын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд БУ-аас ЗХ чигт сунасан 13 км урт, 4 км өргөнтэй хүдэржилтийн бүсэд орших Оюу толгойн бүлэг ордод Херуга, Оюут болон Хюго Дамметт ордууд багтана (5-р зураг).



5-р зураг. Оюу толгойн бүлэг ордын зүсэлт (баруун урдаас зүүн хойшоо)

Оюу толгойн алт-зэсийн голлох нөөцтэй Хюго Дамметт ордод Өмнөд Хюго, Хойд Хюго болон Хойд Хюго үргэлжлэл хэсгүүд хамаардаг. Өмнөд Хюго болон Хойд Хюго хэсгийн хүдэржилт нь >2.5% зэсийн агуулгатай ба хүдэржилтийн бүсүүд Өмнөд Хюго хэсэгт газрын гадаргуугаас 300 м гүнд харин Хойд Хюго хэсэгт 900 м орчим гүнээс тус тус эхэлдэг. Хойд Хюго Үргэлжлэл хэсэг нь Онтрэ компанийн Шивээ Толгой ашиглалтын тусгай зөвшөөрөлт талбайд хамаарагдана. Тэдгээрийн хүдэржилт нь ХЗХ зүг рүү 3 км гаруй сунаж тогтсон байна.

Оюу толгойн алт-зэсийн голлох нөөцтэй Хюго Дамметт ордод Өмнөд Хюго, Хойд Хюго болон Хойд Хюго Үргэлжлэл хэсгүүд хамаардаг. Өмнөд Хюго болон Хойд Хюго хэсгийн хүдэржилт нь >2.5% зэсийн агуулгатай ба хүдэржилтийн бүсүүд Өмнөд Хюго хэсэгт газрын гадаргуугаас 300 м гүнд харин Хойд Хюго хэсэгт 900 м орчим гүнээс тус тус эхэлдэг. Хойд Хюго Үргэлжлэл хэсэг нь Онтрэ

компанийн Шивээ Толгой ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд хамаарагдана. Тэдгээрийн хүдэржилт нь ХЗХ зүг рүү 3 км гаруй сунаж тогтсон байна.

Энд 2015-2018 онуудад шинээр 51 цооногийн 15,567 т.м өрөмдлөгийг гулууз дээжлэлттэй баганат, үртсэн дээжлэлттэй урвуу үлээлгэт хийн цохилтот аргуудаар явуулж, тэдгээрийн өгөгдөл, мэдээлэл нэмэгдэж, хуучин цооногуудад дахин баримтжуулалт, баталгаажуулалт хийсэн байна.

ДҮГНЭЛТ

1. Энэхүү 2 том ордын жишээгээр авч үзэхэд геологийн судалгаа явуулж, эрэл-хайгуул хийж, ашигт малтмалын нөөцийг тооцох тогтооход өрөмдлөг маш чухал, зонхилох үүрэгтэй, иймээс ч хайгуулын шатны нийт зардлын $\frac{3}{4}$, түүнээс ч илүүг зарцуулан явагддаг байна.

2. Өрөмдлөгөөр бий болсон газрын хэвлийн гүний геологийн тогтоц, ашигт малтмалын тархалт, агуулга, нөөцийн мэдээллийг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэж, ихээхэн өртөг зардлаар бий болсон өрөмдлөгийн мэдээллийг хавсралт тайлан болгон архивлан хадгалах, энэ чиглэлээр өрөмдлөгийн мэргэжлийн байгууллага хүмүүсийн оролцоог хангаж, Мэргэшсэн, Зөвлөх үйлчилгээг бий болгох, Шүүмж, шинжээч хийлгэх шаардлагатай болохыг тэмдэглэж, санал болгож байна.

3. Бүхэлдээ их өрөмдөл илүү их олдог зарчмыг анхаарч цаашид геологийн судалгаа, орд, ашигт малтмалын эрэл-хайгуул хэдийгээр өртөг зардал өндөртэй ч өрөмдлөгийг аль болохоор их хэмжээтэй, түлхүү, оновчтой дараалал, байршилтайгаар шуурхай явуулах нь амжилтын гол үндэс болдгийг тэмдэглэж, санал болгож байна.

4. Бүхэлдээ энэ 2 томоохон ордын жишээгээр л авч үзэхэд ихээхэн хөрөнгө оруулалт гарган, өндөр өртөг зардал зарцуулан, хамгийн гол нь гүний бодит мэдээллийг бий болгосон их хэмжээний өрөмдлөгийн үр дүн, гүйцэтгэсэн үүрэг асар их ач холбогдолтой бөгөөд энэ талаар өмнө нь ч, одоо ч, тусгайлан авч үздэггүй, тайлан мэдээлэл гаргадаггүй нь учир дутагдалтай, цаашид АМО-ын хайгуул, нөөцийн тооцооны үйл ажиллагаанд өрөмдлөгийн байгууллага, мэргэжилтнүүдийг оролцуулж байх шаардлагатай болно.

НОМ ЗҮЙ

- [1] Цэвээнжав.Ж, Тувшинбаяр.Д. Зэс-молибден, зэс алтны ордуудын өрөмдлөгийн нөхцлийн судалгаа, үнэлгээ, төрөлжүүлэлт. Хайгуулчин, УБ. 2011. №2/45. 19-24.
- [2] Д.Тувшинбаяр. Геологи-хайгуулын өрөмдлөгийн нөхцөл, технологийн түвшний үнэлгээ (Эрдэнэтийн ордын жишээ дээр. Техникийн ухааны доктор (PhD)-ын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл (удирдагч проф. Ж.Цэвээнжав). УБ-Эрдэнэт, 2011, 105х.
- [3] Ганболд.С, Отгон-Эрдэнэ.Д. Мировая потребность меди и эксплуатация крупных месторождений меди Монголии. В сб. Технологии, экономика и экология горной

промышленности. (на монгольском языке). УБ. 2007. №35. стр265-271.

- [4] О.Батгэрэл, О.Цэдэндамба, Х.Амарзаяа, Д.Баттөмөр, Б.Лхагвасүрэн. Эрдэнэтийн зэс-молибдений ордод 2016-2020 онуудад гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүн, нөөцийн тодотгол тайлангийн танилцуулга. Эрдэнэт-Улаанбаатар, 2021,50х.
- [5] 7. А. Одончимэг, Т.Отгонбаяр, Д. Оюунжаргал, С.Мягмарсүрэн, Б.Мөнхбат. Оюутолгойн зэс-алтны бүлэг ордуудад 2015-2018 онуудад гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүн, нөөцийн тодотгол тайлангийн танилцуулга. Ханбогд-Улаанбаатар, 2021,33х.

II. ЕРӨНХИЙ АСУУДЛУУД

БАЯНГОЛЫН ТӨМРИЙН ОРДЫН ЧУЛУУЛГИЙН ӨРӨМДӨГДӨХ ЗЭРГИЙГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА, ҮР ДҮН

Д.Ундармаа, Ж.Цэвээнжав, Л.Төвхөө, Ц.Удвалхорлоо, Д.Ууганбаяр Д.Сувд-Эрдэнэ, Б.Сувд-Эрдэнэ
Монгол улс, Улаанбаатар, ШУТИС, Геологи уул уурхайн сургууль, Газрын тос өрөмдлөгийн салбар
undarmaad@must.edu.mn, btseven2003@must.edu.mn, tuvkhuu100@must.edu.mn, udvalkhorloo@must.edu.mn

Хураангуй— Өрмийн хушуу нэвтрэхэд чулуулгаас түүнд үзүүлэх эсэргүүцлээр тодорхойлогдох чулуулгийн цогцолбор үзүүлэлтийг тэдгээрийн өрөмдөгдөх чанар гэнэ. Өрөмдөгдөх чанар нь геологийн, технологийн, техникийн зэрэг олон хувьсах хүчин зүйлээс хамаарах функц бөгөөд түүнд чулуулгийн физик-механик шинж чанарууд, тэдгээрийн орших нөхцөл, үзүүрийн багажийн хийц, хэлбэр, хэрэглэж буй технологийн горим зэрэг нөлөөлнө.

Чулуулгийн өрөмдөгдөх зэргийг тодорхой нөхцөлд тогтоох нь материалын нормчлол гаргах, хурдас чулуулгийг өрөмдөгдөх зэргээр нь ангилах, энэ ангиллыг үндэслэж өрөмдлөгийн техник технологийн бүх асуудлуудыг оновчтойгоор шийдвэрлэхэд шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн чухал ач холбогдолтой, тодорхойлох зайлшгүй шаардлагатай юм.

Өрөмдлөгийн ажлын явцад чулуулгийн шинж чанарыг таних, тэдгээрийн үзүүлэлтүүдийг үнэн зөв тодорхойлох нь өрөмдлөгийн арга болон үзүүрийн багаж сонгох, технологийн боловсруулалт хийх, өрөмдлөгийн ажлын техникийн эдийн засгийн үзүүлэлтүүдийг тодорхойлох зэрэгт чухал ач холбогдолтой.

Өрөмдлөгт чулуулгийн өрөмдөгдөх зэргийг тодорхойлохдоо түүний динамик хатуулаг, элээх чанарыг үндэслэн тогтоодог арга зүйг өрөмдлөгийн практикт өргөн ашигладаг. Тус өгүүлэлд Баянголын төмрийн ордын жишээн дээр чулуулгийн өрөмдөгдөх зэргийг тодорхойлсон үр дүнг оруулсан болно.

Түлхүүр үг— өрөмдлөг, өрөмдөгдөх зэрэг, чулуулаг, хатуулаг, ангилал

I. ОРШИЛ

Төмрийн хүдрийн өрөмдлөгийн явцад диорит, гранит, төмөрлөг кварцит, роговит, кварцын судлууд зэрэг өрөмдөгдөх зэрэг өндөртэй чулуулгууд элбэг тохиолдох бөгөөд үзүүрийн багажийн элэгдэлт ихтэй, зарцуулалт өндөр байна. Үзүүрийн багажийн элэгдэлтэнд гол нөлөөлөх хүчин зүйл нь чулуулгийн өрөмдөгдөх зэрэг, чулуулгийн хатуулга байх ба эдгээр үзүүлэлтүүдийг зөв тодорхойлох, тохирсон үзүүрийн багажийг сонгох нь чухал юм.

Судалгаагаар Баянголын төмрийн ордын чулуулгийн дээжүүдэд өрөмдөгдөх зэргийг тодорхойлон үр дүнг тооцов.

II. ЧУЛУУЛГИЙН ӨРӨМДӨГДӨХ ЗЭРГИЙГ ТОДОРХОЙЛОХ АРГАЧЛАЛ

Өрмийн хушуу чулуулагт нэвтрэхэд түүнд чулуулгаас үзүүлэх эсэргүүцлээр тодорхойлогдох цогцолбор үзүүлэлтийг өрөмдөгдөх чанар гэнэ. Тоон утгаараа чулуулгийн өрөмдөгдөх зэрэг нь өрөмдлөгийн механик хурдаар тодорхойлогдоно.

Өрөмдөгдөх чанар нь геологийн, технологийн, техникийн зэрэг олон хувьсах хүчин зүйлээс

хамаарах функц бөгөөд түүнд чулуулгийн физик-механикийн шинж чанарууд, тэдгээрийн орших нөхцөл, үзүүрийн багажийн хийц, хэлбэр, хэрэглэж буй технологийн горим зэрэг нөлөөлнө.

Чулуулгийн өрөмдөгдөх зэргийг тодорхой нөхцөлд тогтоох нь материалын нормчлол гаргах, хурдас чулуулгийг өрөмдөгдөх зэргээр нь ангилах, энэ ангиллыг үндэслэж өрөмдлөгийн техник, технологийн бүх асуудлыг оновчтойгоор шийдвэрлэхэд шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн чухал ач холбогдолтой, тодорхойлох зайлшгүй шаардлагатай юм.

Орчин үед чулуулгийн өрөмдөгдөх зэргийг тодорхойлох олон аргууд байгааг дараах 3 группэд хуваан үзэж болно.

1. Өрөмдөгдөх зэргийг хурдас чулуулгийн петрографийн төрөл, эрдсийн бүрэлдэхүүнээс хамааруулан тогтоох геологийн аргууд.

2. Өрөмдөгдөх зэргийг туршилтын өрөмдлөгөөр хронометрийн ажиглалт хийж тогтоох үйлдвэрлэлийн аргууд.

3. Өрөмдөгдөх зэргийг тодорхой нөхцөлд багажийн тусламжтайгаар тогтоох лабораторийн аргууд.

Эдгээрээс эхний группэд багтах аргууд нь өрөмдлөг явагдах объектод геологичид хурдас чулуулгийн өрөмдөгдөх зэргийг тэдгээрийн петрографийн төрөл, эрдсийн бүрэлдэхүүнээс нь хамааруулан сонгомол дээжүүдтэй жиших замаар баримжаагаар тогтооход орших бөгөөд нарийвчлал муутай, хамгийн гол нь өрөмдлөгийн техник, технологийн асуудлуудыг шийдвэрлэхэд шаардлагатай гол үзүүлэлтүүдийг (хатуулаг, элээх чанар гэх мэт) тооцож тогтоодоггүйгээрээ учир дутагдалтай юм.

Орд объектуудад чулуулгийн физик-механик шинж чанарууд ихээхэн хувирамтгай байх тул туршилтын өрөмдлөгөөр чулуулгийн өрөмдөгдөх зэргийг тогтоох нь ихээхэн хэлбэлзэлтэй байж болох бөгөөд мөн л үзүүрийн багаж сонгох, өрөмдлөгийн технологийн горимуудыг боловсруулахад шаардлагатай гол үзүүлэлтүүдийг тооцож тогтоох нь дутагдалтай байдаг.

Чулуулгийн өрөмдөгдөх зэргийг тогтоох ихээхэн үнэмшилтэй арга нь лабораторийн арга бөгөөд эрэл, хайлуул, олборлолт явагдаж буй томоохон объектуудад чулуулгийн динамик бат бэх болон элээх чанарын зэргийг тодорхойлон үүнийг үндэслэн тодорхой хурдас чулуулгийн өрөмдөгдөх зэргийг лабораторийн нөхцөлд нарийвчлан тогтоогоод дараа нь үйлдвэрлэлд туршилтын өрөмдлөгөөр баталгаажуулдаг.

Дээрх үндэслэл дүгнэлтэд тулгуурлан чулуулгийн өрөмдөгдөх зэргийг тогтоох лабораторийн хэд хэдэн аргуудаас ОХУ-ын ЦНИГРИ (Центральный научно-исследовательский горно-разведочный институт цветных, редких и благородных металлов- Өнгөт, үнэт, ховор металлын хайгуул, уул уурхайн эрдэм шинжилгээний төв институт) институтэд боловсруулсан УСТ41-89-74 салбарын стандартаар батлагдсан аргыг сонгон авч судалгааны ажлыг хийх нь илүү оновчтой гэж үзэв.

Тус аргачлалаар чулуулгийг динамик бат бэхээр нь 1-р хүснэгтийн дагуу 6 ангилдаг.

1-р ХҮСНЭГТ. ЧУЛУУЛГИЙГ ДИНАМИК БАТ БЭХ

Динамик бат бэх		Чулуулгийн тодорхойлолт
Зэрэглэл	Үзүүлэлтийн утга	
I	8	Бага бат бэхтэй
II	8-16	Багавтар бат бэхтэй
III	16-24	Дунд зэргийн бат бэхтэй
IV	24-32	Бат бэх ихтэй
V	32-40	Маш их бат бэхтэй
VI	40	Дээд зэргийн бат бэхтэй




1-р зураг. Чулуулгийн динамик бат бэх тодорхойлох ПОК багаж
1 - чиглүүлэгч хоолой, 2 - корундын нунтаг, 3 - ачааллах цилиндр, 4 - хар тугалган үрэл, 5 - хуваарьтай бүлүүр, 6 - эзэлхүүн хэмжигчийн цилиндр, 7- туухай, 8 - аяга.

Чулуулгийг элээх чанараар нь 6 ангилсныг 2-р хүснэгтэд үзүүлэв.

2-р ХҮСНЭГТ. ЧУЛУУЛГИЙГ ЭЛЭЭХ ЧАНАР

Элээх чанар		Чулуулгийн тодорхойлолт
Зэрэглэл	К _{абр}	
I	0.5	Элээх чанар багатай
II	0.5-1.0	Элээх чанар багавтар
III	1.0-1.5	Элээх чанар дунд зэрэгтэй
IV	1.5-2.0	Элээх чанартай
V	2.0-2.5	Элээх чанар ихтэй
VI	2.5-3.0	Элээх чанар маш ихтэй



2-р зураг. Чулуулгийн элээх чанарыг тодорхойлох ПОАП-2М багаж

Эргэлтэт өрөмдлөгт чулуулгийн өрөмдөгдөх чанарын нэгдсэн үзүүлэлтийг тооцож 12 зэрэглэлд хуваадаг (3-р хүснэгт).

3-р хүснэгт. Чулуулгийн өрөмдөгдөх чанарын нэгдсэн үзүүлэлт, өрөмдөгдөх зэргийн хамаарал

ρ _м	Өрөмдөгдөх зэрэг	ρ _м	Өрөмдөгдөх зэрэг
-	I	10.2-15.1	YII
-	II	15.2-22.7	YIII
2.0-3.0	III	22.8-34.1	IX
3.14-4.5	IV	34.2-51.2	X
4.6-6.7	V	51.3-76.8	XI
6.8-10.1	VI	76.9-115.2	XII

Судалгаанд төмрийн ордыг төлөөлүүлсэн 54 чулуулгийн дээжид өрөмдөгдөх зэргийг тодорхойлох лабораторийн аргачлалын дагуу туршилт, хэмжилтийг хийж гүйцэтгэв.

Судалгааны дээжүүд нь төмрийн хүдэр, элсэн чулуу, габбро, хувирмал чулуу, конгломерат, алевролит, пирротин зэрэг чулуулгийн төрлүүд байна (Хүснэгт-4).

4-р хүснэгт. Чулуулгийн дээжийн нэр, тоо

№	Чулуулгийн нэр	Дээжийн тоо
1	Төмрийн хүдэр	15
2	Элсэн чулуу	15
3	Габбро	2
4	Хувирмал чулуу	1
5	Конгломерат	2
6	Алевролит	17
7	Пирротин	2
Нийт		54



Судалгааны үр дүнг нэгтгэн Хүснэгт-5-д үзүүлэв.

Дүгнэлт

Нийт 54 чулуулгийн дээжийн туршилтын үр дүнгээс үзэхэд хамгийн өрөмдөгдөх зэрэг өндөртэй нь XIX категорын (төмрийн хүдэр, элсэн чулуу, алевролит), хамгийн бага өрөмдөгдөх зэрэгтэй нь XV-XVII категорын (габбро, элсэн чулуу, алевролит) үзүүлэлттэй байна.

Туршилтаас үзэхэд чулуулгуудын өрөмдөгдөх зэрэг нь харьцангуй өндөр гарч байна. Зарим ижил төрлийн чулуулгууд харилцан адилгүй өөр өөр категорт байгаа нь чулуулгуудад хатуулаг өндөртэй эрдсүүдийн агуулгын хэмжээнээс хамаарсан байх талтай гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

- [1] Өрөмдлөг-19 Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ. 2019 он.
- [2] Л.Г.Грабчак, С.А.Брылов, В.И.Комащенко “Проведение горно-разведочного выработок и основы разработки месторождений полезных ископаемых” М., Недра., 1988
- [3] Ш.Б.Багдасаров, А.О.Верчеба, И.И.Пальмов “Справочник горного инженера геолога разведочных партий” М., Недра., 1986
- [4] Ж.Цэвээнжав, М.Банди, Л.Төвхөө, Л.Дүгэржав. Чулуулгийн өрөмдлөгт нөлөөлөх шинж чанаруудын судалгааны иж бүрэн аргачлал. Улаанбаатар. 1992.

4-Р ХҮСНЭГТ. ТУРШИЛТЫН ҮР ДҮН

Туршилтын дугаар		Чулуулгийн дээжийн дугаар	Чулуулгийн нэр	Динамик хатуулаг				Элээх чанар				Өрөмдөгдөх зэргийн тооцоо	
№	Тухайн дээжийн туршилтын дугаар			n	h, мм	Fg	Дундаж Fg	Q ₁ , мг	Q ₂ , мг	K _{абр}	Дундаж K _{абр}	ρ, нэгдсэн үзүүлэлт	Өрөмдөгдөх зэрэг
1	1	E2101	Төмрийн хүдэр	20	3	133	116.6	1075	975	1	0.875	118.2	XIX
	2			20	4	100		1090	1015	0.75			
2	1	E2102	Элсэн чулуу	20	4	100	100	965	885	0.8	0.875	104.5	XIX
	2			20	4	100		1040	945	0.95			
3	1	E2103	Габбро	20	8	50	50	1090	1035	0.55	0.75	51.4	XVII
	2			20	8	50		980	885	0.95			
4	1	E2104	Хувирмал чулуу	20	2.4	166.6	166.6	970	930	0.4	0.575	103.3	XIX
	2			20	2.4	166.6		1120	1045	0.75			
5	1	E2105	Элсэн чулуу	20	8	50	50	925	880	0.45	0.575	39.4	XVII
	2			20	8	50		955	885	0.7			
6	1	E2106	Элсэн чулуу	20	4	100	90	950	905	0.45	0.625	68.6	XVIII
	2			20	5	80		1145	1065	0.8			
7	1	E2107	Конгломерат	20	8	50	75	1125	1095	0.3	0.7	66.4	XVIII
	2			20	4	100		1065	955	1.1			
8	1	E2108	Алевролит	20	4	100	90	985	900	0.85	0.925	101.5	XIX
	2			20	5	80		1005	905	1			
9	1	E2109	Төмрийн хүдэр	20	3.4	117.6	125.4	1125	1010	1.15	0.9	128.8	XIX
	2			20	3	133.3		985	920	0.65			
10	1	E2111	Элсэн чулуу	20	6	66.6	55.5	1070	1025	0.45	0.525	39.1	XVII
	2			20	9	44.4		1000	940	0.6			

11	1	E2112	Габбро	20	8	50	45	1005	925	0.8	0.85	53.5	XVII
	2			20	10	40		1065	975	0.9			
12	1	E2113	Элсэн чулуу	20	5	80	73.3	1100	1005	0.95	0.825	76.8	XVIII
	2			20	6	66.6		1035	965	0.7			
13	1	E2114	Элсэн чулуу	20	8	50	47.2	1010	890	1.2	0.925	60.6	XVIII
	2			20	9	44.4		1105	1040	0.65			
14	1	E2115	Элсэн чулуу	20	10	40	45	1100	1035	0.65	0.65	40.9	XVII
	2			20	8	50		1045	980	0.65			
15	1	E2116	Алевролит	20	8	50	50	940	910	0.3	0.475	32.5	XV
	2			20	8	50		910	845	0.65			
16	1	E2117	Төмрийн хүдэр	20	4	100	88.4	890	855	0.35	0.425	46	XVII
	2			20	5.2	76.9		1060	1010	0.5			
17	1	E2118	Элсэн чулуу	20	12	33.3	33.3	990	940	0.5	0.8	39.6	XVII
	2			20	12	33.3		1085	975	1.1			
18	1	E2119	Элсэн чулуу	20	18	22.2	22.2	960	875	0.85	0.9	32.2	XV
	2			20	18	22.2		1050	955	0.95			
19	1	E2120	Төмрийн хүдэр	20	4	100	100	995	910	0.85	0.625	74.6	XVIII
	2			20	4	100		1005	965	0.4			
20	1	E2121	Алевролит	20	5	80	90	1010	915	0.95	0.875	96	XIX
	2			20	4	100		1105	1025	0.8			
21	1	E2122	Алевролит	20	8	50	50	1045	990	0.55	0.525	36	XVI
	2			20	8	50		1090	1040	0.5			
22	1	E2123	Элсэн чулуу	20	5	80	65	1105	1055	0.5	0.675	57.1	XVII
	2			20	8	50		1020	935	0.85			
23	1	E2124	Төмрийн хүдэр	20	9	44.4	38.8	905	870	0.35	0.425	23.8	XV
	2			20	12	33.3		980	930	0.5			

24	1	E2125	Элсэн чулуу	20	8	50	45	980	915	0.65	0.55	34.6	XVI
	2			20	10	40		1005	960	0.45			
25	1	E2126	Алевролит	20	4	100	75	1065	985	0.8	0.7	66.4	XVIII
	2			20	8	50		985	925	0.6			
26	1	E2128	Алевролит	20	12	33.3	36.6	1050	1010	0.4	0.425	22.7	XV
	2			20	10	40		900	855	0.45			
27	1	E2129	Төмрийн хүдэр	20	7.2	55.5	62.2	1085	1050	0.35	0.375	30.6	XV
	2			20	5.8	68.9		990	950	0.4			
28	1	E2130	Төмрийн хүдэр	20	6	66.6	61.9	960	910	0.5	0.7	56.9	XVII
	2			20	7	57.1		980	890	0.9			
29	1	E2131	Алевролит	20	6	66.6	58.3	900	820	0.8	0.925	71.7	XVIII
	2			20	8	50		1015	910	1.05			
30	1	E2132	Алевролит	20	5	80	80	910	825	0.85	0.725	72.4	XVIII
	2			20	5	80		1095	1035	0.6			
31	1	E2133	Алевролит	20	4	100	116.6	980	870	1.1	0.95	128.3	XIX
	2			20	3	133.3		1030	950	0.8			
32	1	E2134	Алевролит	20	4	100	100	1060	960	1	0.8	95.5	XIX
	2			20	4	100		1145	1085	0.6			
33	1	E2135	Конгломерат	20	14	28.5	26.7	1025	970	0.55	0.55	22.8	XV
	2			20	16	25		1145	1090	0.55			
34	1	PR-1	Пирротин	20	2.8	142.8	148.3	1055	975	0.8	0.7	114.6	XIX
	2			20	2.6	153.8		1020	960	0.6			
35	1	W2101	Алевролит	20	6	66.6	83.3	985	880	1.05	1.175	121.2	XIX
	2			20	4	100		1055	925	1.3			
36	1	W2102	Алевролит	20	8	50	53.7	990	920	0.7	0.725	52.5	XVII
	2			20	7	57.1		975	900	0.75			

37	1	W2103	Төмрийн хүдэр	20	16	25	25	1110	1020	0.9	0.9	35.4	XVI
	2			20	16	25		1120	1030	0.9			
38	1	W2104	Элсэн чулуу	20	4	100	90	1000	930	0.7	0.8	87.8	XIX
	2			20	5	80		1005	915	0.9			
39	1	W2105	Пирротин	20	5	80	90	990	940	0.5	0.625	68.6	XVIII
	2			20	4	100		1080	1005	0.75			
40	1	W2106	Алевролит	20	4	100	83.3	955	910	0.45	0.45	46.4	XVII
	2			20	6	66.6		930	885	0.45			
41	1	W2107	Төмрийн хүдэр	20	14	28.5	32.4	960	895	0.65	0.675	32.7	XVI
	2			20	11	36.3		1090	1020	0.7			
42	1	W2108	Элсэн чулуу	20	8	50	50	985	970	0.15	0.375	25.7	XV
	2			20	8	50		960	900	0.6			
43	1	W2109	Алевролит	20	5	80	65	980	880	1	0.9	76.1	XVIII
	2			20	8	50		1080	1000	0.8			
44	1	W2110	Алевролит	20	6	66.6	66.6	1045	990	0.55	0.575	49.6	XVII
	2			20	6	66.6		1025	965	0.6			
45	1	W2111	Төмрийн хүдэр	20	10	40	35.3	960	900	0.6	0.725	37.7	XVI
	2			20	13	30.7		1050	965	0.85			
46	1	W2112	Төмрийн хүдэр	20	4.6	86.9	72	925	840	0.85	0.875	80.3	XVIII
	2			20	7	57.1		1035	945	0.9			
47	1	W2113	Төмрийн хүдэр	20	3.6	111.1	69.8	965	905	0.6	0.675	60.4	XVIII
	2			20	14	28.5		1020	945	0.75			
48	1	W2114	Төмрийн хүдэр	20	4.4	90.9	93	1015	995	0.2	0.55	62	XVIII
	2			20	4.2	95.2		1070	980	0.9			
49	1	W2115	Алевролит	20	8	50	58.3	1040	935	1.05	0.545	42.2	XVII
	2			20	6	66.6		909	905	0.04			

50	1	W2116	Алевролит	20	12	33.3	50	1055	960	0.95	0.975	66.8	XVIII
	2			20	6	66.6		990	890	1			
51	1	W2117	Төмрийн хүдэр	20	5	80	92.6	1035	930	1.05	0.75	84.2	XIX
	2			20	3.8	105.2		1090	1045	0.45			
52	1	W2118	Төмрийн хүдэр	20	6	66.6	58.3	950	880	0.7	0.625	48.4	XVII
	2			20	8	50		1025	970	0.55			
53	1	W2119	Элсэн чулуу	20	4	100	100	905	855	0.5	0.625	74.6	XVIII
	2			20	4	100		1065	990	0.75			
54	1	W2120	Элсэн чулуу	20	8	50	50	1085	995	0.9	0.875	60	XVIII
	2			20	8	50		1070	985	0.85			

ЭРДЭНЭТИЙН-ОВОО ОРДЫН ӨРӨМДЛӨГИЙН УГААЛГЫН ШИНГЭНИЙ ШИНЖ ЧАНАРЫН СУДАЛГАА

Д.Ундармаа¹, Ж.Цэвээнжав¹, Т.Майнбаяр², Б.Эрдэнэбаяр²

Монгол улс, Улаанбаатар, ШУТИС, Геологи, уул уурхайн сургууль, Газрын тос өрөмдлөгийн салбар

¹ Монгол улс, Улаанбаатар, ШУТИС, Геологи, уул уурхайн сургууль

² Монгол улс, Эрдэнэт, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, ГХА

undarmaad1976@yahoo.com, btseveen2003@yahoo.com,

Хураангуй— Эрдэнэтийн зэс молибдений ордын геологийн хагарал ан цавшилт болон ил уурхайн тэсэлгээний үйлчлэлээр чулуулгийн ан цавшилт ихсэж, хэт их ан цавархаг болж бутралд орсноос өрөмдлөгийн үед механик хурд, дээжийн гарц, цооногийн ханын тогтворжилт зэрэг үзүүлэлтүүд буурч угаалгын шингэний алдагдал болон алмазан хушууны элэгдэл ихэссэн байна. Иймээс энэ асуудлыг шийдэх нэг арга нь цооногийн угаалга, угаалгын шингэний технологийн шинж чанар бөгөөд тухайн геологийн нөхцөлд тохирсон технологийн судалгааг хийх нь чухал байна.

Түлхүүр үг— Цооногийн угаалга, угаалгын шингэн, угаалгын шингэний технологийн шинж чанар

I. УДИРТГАЛ

Эрдэнэтийн овооны зэс-молибдений ордыг эрж хайх, нөөцийг тогтоох, олборлоход өрөмдлөгийн ажил чухал үүрэгтэй бөгөөд цаашдаа ч ач холбогдолтой хэвээр байна. Уг ордыг олж илрүүлсэн 1960-аад оноос хойш 50 гаруй жилийн хугацаанд бидний тооцоолсноор энэ ордод болон түүний ойролцоо дүүргүүдэд нийт 60 мянга орчим тууш метр хайгуулын, 4.8 сая гаруй тууш метр ашиглалтын (тэсэлгээний), 8 мянга гаруй тууш метр усны эрэл хайгуулын өрөмдлөгийг явуулжээ.

Өнөөдөр Эрдэнэтийн ордод геологи хайгуулын, уурхайн ашиглалтын, геотехнологийн, гидрогеологийн, инженер-геологийн зэрэг өрөмдлөгийн олон арга, технологийг хэрэглэсэн цогцолбор судалгаа, олборлолтын ажил явагдаж байна.

1990-ээд оноос хойш буюу зах зээлийн эдийн засагт шилжсэний дараа Эрдэнэтийн уул уурхайн цогцолборын шугамаар дээрхи чиглэлүүдээр гол төлөв уурхайн болон технологийн цооногуудын өрөмдлөг хийгдсэн байна.

Эрдэнэтийн зэс молибдений ордын Төвийн хэсгийн гүйцээх хайгуул, Баруун хойд хэсгийн хүдрийн ил уурхай болон уурхайн талбайд ашиглалтын хайгуулын цооногуудыг өрөмдөх үед чулуулгийн ан цавшилтаас шалтгаалан үүсэх хүндрэлүүд нь судлах шаардлагатай чухал асуудлуудын нэг юм.

II. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Өрөмдлөгийн угаалгын шингэн гэсэн ойлголтонд бутлагдсан чулуулгийн үртсийг цооногоос гаргах, цэвэрлэх зориулалттай ашиглагдаж байгаа бүх төрлийн ажлын шингэнийг ойлгох бөгөөд өрөмдлөгийн угаалгын шингэн нь анхандаа бутлагдсан үртсийг тээвэрлэх, үзүүрийн

багажийг хөргөх зорилгоор ашиглагдаж байсан ба цаг хугацааны явцад өрөмдлөг нь геологийн янз бүрийн хүндрэлтэй нөхцөлд илүү гүнд, тогтворгүй хурдас чулуулгийг өрөмдөж нэвтрэх болсноос олон төрлийн үүргүүдийг давхар гүйцэтгэх шаардлага гарч ирсэн.

Геологийн янз бүрийн хүндрэлтэй нөхцөлд хэрэглэхийн тулд угаалгын шингэний шинж чанарыг сайжруулах, боловсруулах зорилгоор нэмэлт химийн урвалж, бодисуудыг хэрэглэх, тэдгээрийн шинж чанарыг хянах шаардлагууд гарч ирсэн байна.

Эрдэнэтийн зэс молибдений ордын геологийн хагарал ан цавшилт болон ил уурхайн тэсэлгээний үйлчлэлээр хүдэр чулуулгийн ан цавшилт ихсэж, хэт их ан цавархаг болж бутралд орсноос өрөмдлөгийн үед механик хурд, дээжийн гарц, цооногийн ханын тогтворжилт зэрэг үзүүлэлтүүд буурч угаалгын шингэний алдагдал болон алмазан хушууны элэгдэл ихэссэн.

Эрдэнэтийн-Овоо ордын төвийн хэсэгт хийсэн чулуулгийн өрөмдөгдөх зэргийг тогтоох судалгаанаас үзэхэд чулуулаг нь кварцжиж нягтаршсан бат бөх трахиандизет бүхий эффузив чулуулаг, кварцын агуулга өндөр метасоматит, жижиг ширхэгтэй, 10-30% порфир шигтгээтэй гранодиорит, аплит маягийн боржин тэдгээрийн кварцжилтад орсон хүдэржсэн хэсэг маш хатуу, буюу өрөмдөгдөх зэрэг өндөр байна. Динамик бат бэхийн хувьд туршилтанд хамрагдсан нийт чулуулгийн 4% нь дунд зэргийн бат бэх, 27% нь бат бэх ихтэй, 69% нь маш бат бэх гэсэн ангилалд орж байна.

Эрдэнэтийн-Овоо ордын баруун хойд (ил уурхай) төвийн хэсэгт гүйцэтгэсэн өрөмдлөгийн ажилд зарцуулагдсан алмазан хушуунуудын элэгдлийг төрлөөр нь ангилж үзэхэд хэвийн жигд

элэгдсэн өрмийн хушуу 34%-ийг эзэлж байгаа бол 66% нь зүй бусаар элэгдсэн байсан. Алмазан хушуунуудын матриц бүрэн элэгдэж дуусаагүй байхад хушуу аль нэг хэсгээрээ түрүүлж элэгдсэнээр хушууны хувийн үзүүлэлт муудаж хайгуулын ажлын зардлыг өсгөж байна. Үүний гол шалтгаан нь өрөмдлөгийн угаалгын шингэний буруу сонголт, цооногийн хананы тогтворжилт муу, өрөмдлөгөөс үүссэн чулуулгийн үртэс бүрэн цэвэрлэгдэж, зөөгдөхгүйн улмаас дахин өрөмдөгдөж байгаа явдал юм.

Иймээс судалгааг Эрдэнэтийн овоо ордын төвийн хэсэгт 2021 онд өрөмдсөн геотехникийн GT21004, GT21003 цооногуудын өрөмдлөгийн ажлын жишээн дээр гүйцэтгэж, өрөмдлөгийн үеийн хүндрэлийг үнэлэх, угаалгын шингэний технологийн шинж чанарыг судлах зорилго тавилаа. Судалгааны явцад угаалгын шингэний технологийн үзүүлэлтүүдийг шингэний лабораторийн багаж төхөөрөмжөөр тодорхойлон үр дүнг Хүснэгт-1 -д үзүүлэв.

1-Р ХҮСНЭГТ. УГААЛГЫН ШИНГЭНИЙ
ШИНЖ ЧАНАРЫН СУДАЛГААНЫ ДҮН

Өрөмдөгч			Цооногийн		Ээлж		Өрмийн бригад		Огноо				
Н.Энхболд			Q, л/ми	Зумфны	өдөр		ҮЛ-900		2021.11.01				
Өрөмдөхөөс өмнөх үеийн		нягт	45	6м3	Угаалгын шингэн		Орц, кг	Чулуулгийн нэр	Чулуулгийн хатуулаг	Интервал, м			
					Элсний агууламж								
1.02	0		45	6м³		CHP		3	GDR	IX	250	230	1
1.02	0		45	6м³		CHP		3	GDR	IX	596	261	2
1.03	1		45	6м³		CHP		3	GDR	IX	268	271	3
1.02	1		45	6м³		CHP		3	GDR	IX	271	273	4
1.01	0		51	6м³		CHP		4	GDR	IX	450	453	5
1.00	2		51	6м³		CHP		5	GDR	IX	470	472	6
1.02	2		51	6м³		CHP		5	GDR	IX	500	503	7

	Судалгаа хийсэн				Ил уурхай			
	Б.Эрдэнэбаяр							
pH	Эргэлтэд орох үеийн үзүүлэлт			Цооногос гарч байгаа үеийн үзүүлэлт				
	зууралдлага	нягт	Элсний агууламж	зууралдлага	нягт	Элсний агууламж	зууралдлага	
5	21.73	1.02	0	22.3	1.04	1	25.5	
5	21.73	1.02	0	22.3	1.04	0	25.5	
5	18.5	1.01	1	19.1	1.02	0	20.2	
5	16.3	1.01	1	16.9	1.04	1	18.5	
5	15.0	1.00	1	15.6	1.00	1	27.0	
5	15.2	1.00	1	15.9	1.00	0	27.0	
5	14.5	1.00	1	14.7	1.01	0	28.0	

Хүснэгт-1-д үзүүлсэн судалгааны дүнгээс үзэхэд:

Усны рН үзүүлэлт: Эрдэнэтийн овоо ордын өрөмдлөгт ашиглаж байгаа технологийн ус нь хүчиллэг (рН=5) байгаа ба үүнээс хамааран бентонитийн уусмал зуурахад задрах боловч хөдөлгөөнгүй тодорхой хугацааны дараа доош тунаж, суулт өгч байгаа нь ажиглагдсан юм.

Өмнө хийгдсэн судалгаануудаас үзэхэд угаалгын шингэний шинж чанарт угаалгын шингэнийг бэлтгэх материалын болон усны шинж чанар нь ихээхэн нөлөөлөх ба угаалгын шингэн бэлтгэх усны шинж чанарыг рН, давсны агуулга, усны хатуулаг гэсэн үндсэн 3 хүчин зүйлсээр тодорхойлж болно.

Усны pH үзүүлэлт нь усны хүчиллэг эсвэл шүлтлэг шинжийг илэрхийлдэг үзүүлэлт бөгөөд дээжийн гарцыг сайжруулах, цооногийг тогтворжуулах, цооногт ус алдалтыг зогсоох, угаалгын шингэний зууралдлага, угаалгын шингэн бэлтгэхэд чухал нөлөөтэй. юм. Устөрөгчийн илтгэгч үзүүлэлт болох pH нь цэвэр усанд pH=7, pH нь 7-оос доош бол хүчиллэг, дээш бол шүлтлэг гэж үздэг. Өөрмдлөгт усны pH=8-9 байх нөхцөлд бентонит нь хамгийн сайн холигдох бөгөөд мөн ижил шүлтлэгтэй үед бентонитийн хөөлт хамгийн өндөр байдаг. Мөн

усан дахь pH=8-9 байх үед полимер нь хамгийн сайн шинж чанарыг үзүүлдэг.

Дээрхээс үзэхэд усны pH үзүүлэлтээс хамааран бэлтгэсэн уусмал нь өрөмдлөгийн үед бүрэн задарч найрагдаагүйгээс цооногийн ханыг тогтворжуулах, үртсийн зөөгдөлтөнд сөрөг нөлөө үзүүлж байна гэж үзэв.

Уусмалын нягт, зууралдлага: Судалгаанаас үзэхэд цооногоос гарч байгаа болон цооног руу орж байгаа уусмалын нягт ± 0.01 –ээр өөрчлөгдөж байгаа нь өрөмдлөгийн үед чулуулгийн үртэс бага үүсэж байгааг, зарим тохиолдолд нягт нь буурч байгаа нь цооногт уст үе таарсан байж болзошгүйг харуулж байна. Нягттай уялдаж зууралдлагыг үзүүлэлт нь 5-7 хүртэл секундээр өөрчлөгдөж байгаа юм.

Уусмалын элсний хэмжээ: Угаалгын шингэний элсний хэмжээ нь өрөмдөгдсөн чулуулгийн үртсийн хэмжээтэй холбоотой бөгөөд элсний хэмжээ 2-4%-ийн агуулгатай байгаа нь цооногуудад өрөмдлөгийн үед чулуулгийн үртэс зөөгдөлт муу явагдаж байгааг харуулж байна.

Түүнчлэн, судалгааны объект болох геотехникийн GT21004, GT21003 дугаар цооногуудын өрөмдлөгийн үед ан цавархаг үеүүдэд угаалгын шингэний алдагдал ихээр тохиолдож байв. Тухайлбал, GT21004 цооног өрөмдлөгийн явцад (100-280м) угаалгын шингэний алдагдал үүсэн, угаалгын шингэний алдагдлыг бууруулах зорилгоор бентонитийн уусмал болон бусад уусмалын алдагдлыг багасгах зориулалттай химийн урвалжуудыг ашигласан боловч (320м) угаалгын шингэн бүрэн алдагдалд орж өрөмдлөгт хүндрэл учруулж байсан юм. Тухайн цооног нь 70⁰ налуу өрөмдлөг хийж шавар уусмалаар цооногийн хананд бүрхүүл үүсгэж угаалгын шингэний алдагдлыг багасгаж байсан боловч өрөмдлөгийн сумыг хэт хурдан өргөж буулгах явцад хананд үүссэн бүрхүүлийг арилгаж угаалгын шингэн алдах гол шалтгаан болсон гэж үзэж байна.

GT21003 цооногийн хувьд мөн л 70⁰ налуу өрөмдлөг хийж байсан боловч угаалгын шингэний алдагдал харьцангуй бага, 0-40м цооногийн хана нурултай шаврын уусмал хэрэглэж өрөмдлөг хийгдэж байсан. 50-300м өрөмдлөг харьцангуй тогтвортой явагдаж байсан. 300-560м цооног шламжих шинжтэй байсан. Энэ үед цооногийн хана харьцангуй тогтвортой дээж гулууз, гарц 100% байсан учир угаалгын шингэний зууралдлагыг

нэмэгдүүлж тухайн цооногийг төслийн гүнд хүргэсэн.

Цооног өрөмдлөгийн үеийн угаалгын шингэний алдагдал нь хамгийн өргөн тархсан геологийн хүндрэлүүдийн нэг юм. Алмазан өрөмдлөгт шингэн алдагдлыг зогсооход богино хугацаанд усанд хурдан хатуурах бодисын нэмэгдэлтэй цементээр бэлтгэдэг.

ДҮГНЭЛТ

Судалгаанаас дүгнэж үзэхэд өрөмдлөгийн үед угаалгын шингэний шинж чанар харьцангуй тогтвортой, өрөмдлөгийн үед угаалгын шингэн бэлтгэхдээ оновчтой найрлага, бэлтгэх технологийн горимыг баримтлаагүй тал ажиглагдаж байгаа бөгөөд үүнээс үүдэн цооногийн хана хөөх, нурах, угаалгын шингэний сан үртэсжих, дээжийн уусалт, угаалт зэрэг хүндрэлүүд үүсэж байна. Ялангуяа, угаалгын шингэн бэлтгэх усны шинж чанарт анхаарах, усны pH үзүүлэлтийг хянах шаардлагатай гэж үзлээ.

Өрмийн уусмал бэлтгэх үндсэн технологи нь шаардлагатай шаврын нунтаг, химийн урвалж материалын орцыг тооцон хольж хутгаж бэлтгэхэд оршино. Уусмал бэлтгэх технологи нь түүхий эд материалын шинж чанар, бэлтгэх технологийн горимоос хамаарах үндэслэлтэй бөгөөд уусмалын шинж чанарт ихээхэн нөлөөлөл үзүүлдэг. Энэ нь уг бүтээгдэхүүнийг дагалдан ирсэн техникийн баримт бичигт заагдсан найрлагаар бэлтгээгүй, мөн уусмалын хутгалт, холилтыг дутуу хийснээс ихээхэн шалтгаална.

Технологийн горимоор бэлтгэсэн уусмалыг өрөмдлөгийн явцад шинж чанарыг, ялангуяа нягт, зууралдлага, элсний агуулга гэсэн үзүүлэлтүүдийг 7-8 цаг тутамд байнга хэмжиж, хянаж, өрөмдлөгийн ажлын журнал дээр тэмдэглэж занших нь бас чухал байна.

НОМЗҮЙ

- [1] Ж.Цэвээнжав, Д.Ундармаа, Ц.Удвалхорлоо “Өрөмдлөгийн үзүүлэлтүүд угаалгын шингэний төрөл, шинж чанараас хамаарах байдал” Монгол орны өрөмдлөгийн албаны тулгамдсан асуудлууд. УБ. 2001. 1/3. 44-56х.
- [2] Ж.Цэвээнжав, Л.Дүгэржав, Т.Чингис “Өрөмдлөгийн уусмалын шинж чанарыг тодорхойлох лабораторийн ажлын гарын авлага” УБ.2020 он
- [3] П.Ганбаатар, Д.Ундармаа, Х.Насанжаргал “Цооногийн ханын тогтвортой байдалд өрмийн угаах шингэний нөлөөлөл”, Монгол орны өрөмдлөгийн албаны тулгамдсан асуудлууд 2010, 1/12, 54-60х.

ДАЛД УУРХАЙН ӨРӨМДЛӨГИЙН УГААЛГЫН ШИНГЭНИЙ СУДАЛГАА

Д.Ундармаа¹, З.Болд-Эрдэнэ², Ж.Бат²

¹Монгол улс, Улаанбаатар, ШУТИС, Геологи уул уурхайн сургууль, Газрын тос өрөмдлөгийн салбар

² Монгол улс, Улаанбаатар, "Мэйжор дриллинг" ХХК

undarmaad1976@yahoo.com

Хураангуй— Аливаа ордыг далд аргаар ашиглах нь ихээхэн хүн хүч, хөрөнгө мөнгө, нарийн технологи шаарддаг. Далд уурхайн процесс нь өөр хоорондоо нягт уялдаа холбоотой нийлмэл ажиллагаа юм. Далд уурхайн өрөмдлөг нь цооногийн зориулалтаасаа хамааран газрын гүнд, тодорхой чиглэлийн дагуу өрөмдөгддөг. Өрөмдлөгийн техник, технологийн хувьд газрын гадаргуугийн өрөмдлөгтэй ижил эргэлтэт өрөмдлөгийн аргаар ижил технологиор өрөмдөх боловч, цооногийн зориулалт, чиглэлээс хамааран өрөмдлөгийн нөхцөл, цооног цэвэрлэгээний технологийн горимыг нарийн тооцох шаардлагатай юм..

Түлхүүр үг— Далд уурхайн өрөмдлөг, угаалгын шингэн, цооногийн хазайлт, үртэс зөөгдөл

I. УДИРТГАЛ

Дэлхийд томоохонд тооцогддог “Оюу толгой” зэс-порфирийн ордыг ашиглах үйл ажиллагааны шинэ шатны гараа болох далд уурхайн бүтээн байгуулалтын гол хэсэг нь далд уурхайд хийх тэсэлгээ, бэхэлгээний зориулалттай хийгдэх өрөмдлөгийн ажил юм.

Аливаа хайгуулын, ашиглалтын, бэхэлгээний зэрэг зориулалттай цооног өрөмдлөгийн үед өрөмдлөгийн нөхцөл, чулуулгийн шинж чанарыг судлах, түүнд тохирсон өрөмдлөгийн арга, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, технологийг судлах зайлшгүй шаардлагатай байдаг.

Монгол улсын төдийгүй дэлхийн томоохон төслүүдийн нэгд зүй ёсоор багтах Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтын голлох үйл ажиллагааны нэг нь далд уурхайн тэсэлгээ болон бэхэлгээний өрөмдлөгийн ажил билээ. Далд уурхайд хийгдэж буй хэдэн мянган тууш метр өрөмдлөгийн ажлыг аюулгүй, хурдан шуурхай, дэвшилтэт технологид суурилан хийх нь эрхэм зорилго билээ.

Судалгааны ажлаар Оюутолгойн далд уурхайд хийгдэж буй тэсэлгээ болон бэхэлгээний цооног өрөмдлөгийн үеийн хурдас чулуулаг, түүний шинж чанарт тохирсон цооног цэвэрлэх угаалгын шингэний технологийн үзүүлэлтүүдийг судлах ажлын хүрээнд чулуулгийн шинж чанар, түүний өрөмдлөгийн механик хурд болон цооногийн хазайлтын өнцөгт нөлөөлөх нөлөөллийг судлах, тэдгээрийн хоорондын хамаарлыг тогтоох зорилт тавьсан.

II. СУДАЛГААНЫ ХЭСЭГ


“Оюу толгой” зэс-порфирийн ордын өрөмдлөгт ордын өрөмдлөгт RC буюу хийн үлээлэгтэй эргэлтэт-цохилтот өрөмдлөг, гулууз дээж сугалагчтай алмазан өрөмдлөгийн аргыг ашиглаж байна.

- Газрын гадаргуугийн өрөмдлөгт RD1500, UDR1500, UDR650, JKS300, CS1000, Boartlongyear зэрэг өрөмдлөгийн тоног төхөөрөмжүүдийг ашиглаж байна. Эдгээр төхөөрөмжүүд нь өрөмдлөгийн явцад яндангийн цувааг сугалахгүйгээр дээжээ авдаг, өрөмдлөгийн нэвтрэлтийн хурд, хүч өндөртэй төхөөрөмжүүд юм. Өрөмдлөгийн дээжийн голч PQ (103.2mm), HQ (77.8 mm), NQ (60.3mm), BQ (46mm) байдаг. Түүнчлэн их гүний хүдрийн биетийг өрөмдөхөд цаг зардлыг хэмнэх ач холбогдолтой, тодорхой гүнээс цооногийн чиглэлийг өөрчлөх, налуугаар болон салаалуулж өрөмдөх Navidrill технологийг ашиглаж байна.

- Далд уурхайн геотехникийн тандалт судалгааны өрөмдлөгт UDR төрлийн хайгуулын болон Boartlongyear компанийн LM90, MDR700 болон Epiroc Diamec Smart өрмийн төхөөрөмжүүдийг ашиглаж байна.



Эргэлтэт өрөмдлөгийн UDR1500 өрмийн төхөөрөмж



Далд уурхайн LM90 өрмийн төхөөрөмж



Эргэлтэт өрөмдлөгийн JKS300 өрмийн төхөөрөмж



Далд уурхайн Epiroc Diamec smart-8 өрмийн төхөөрөмж

1-р зураг. Оюу толгойн ордын өрөмдлөгт ашиглагдаж байгаа өрөмдлөгийн төхөөрөмжийн төрлүүд

Далд уурхайн өрөмдлөгийн үед дараах хүндрэлүүд тохиолдож байна. Үүнд:

Угаалгын шингэний алдагдал: Далд уурхайн өрөмдлөг нь гадаргуугийн босоо цооногийн өрөмдлөгтэй харьцуулахад үе давхаргыг босоо тэнхлэгээр биш хэвтээ тэнхлэгийн дагуу дайрч өнгөрөх тул угаалгын шингэний алдалт үүсгэх хурдас чулуулгийн үе таарах үед ус алдах бүсийн хэмжээ их байна.

Өрмийн сум гацах: Далд уурхайн өрөмдлөг нь гадаргуугийн босоо цооногийн өрөмдлөгтэй харьцуулахад үе давхаргыг босоо тэнхлэгээр биш хэвтээ тэнхлэгийн дагуу дайрч өнгөрөх тул давхаргын даралтын хэмжээ, хүчний шууд үйлчлэх гадаргуугийн хэмжээ их байна.

Цооног хангалттай цэвэрлэгдэхгүй байх: Далд уурхайн өрөмдлөг нь хэвтээ тэнхлэгийн дагуу явагдах ба цооногийн хазайлтын өнцгийг үл ялиг өөрчлөхөд угаалгын шингэний үртэс тээвэрлэх, өргөх хүчинд нөлөөлнө. Өөрөөр хэлбэл өрөмдлөгийг босоогоос хэвтээ чиглэлд шилжүүлэхэд өрөмдлөгийн шингэний үртэс зөөвөрлөх хүчин чадал буурах болно. Энэ нь үртэс дээшээ өргөгдөх гэхээсээ илүү цагирган хэлбэртэй биетийн хажуугийн ханыг дагаж доошоо унах хандлагаас болж үүсдэг.

Нэвтрэлтийн хурд удаашрах: Далд уурхайн өрөмдлөг нь босоогоос хэвтээ чиглэлд шилжүүлэхэд өрөмдлөгийн шингэний үртэс зөөвөрлөх хүчин чадал буурах болно. Энэ нь үртэс дээшээ өргөгдөх гэхээсээ илүү цагирган хэлбэртэй биетийн хажуугийн ханыг дагаж доошоо унах хандлагаас болж үүсдэг. Үртэс гаргалтыг сайжруулахад илүү зууралдлага ихтэй өрмийн уусмал ашиглах шаардлагатай бөгөөд энэ нь нэвтрэлтийн хурданд сөргөөр нөлөөлөх талтай.

Дээжийн гарц буурах: Далд уурхайн хайгуулын өрөмдлөг нь босоо цооногтой ижил технологиор явагдах тул дээжний гарцад нөлөөлөх зүйлгүй, дээж авалт 95%-аас багагүй байх гэсэн шаардлагыг хангана.

Угаалгын систем: Далд уурхайн хайгуулын өрөмдлөг нь газрын гүнд буюу Оюу толгойн ордын хувьд одоогоор 1300м-ийн гүнд өрөмдлөгийн тоног төхөөрөмжүүд бусад багаж хэрэгслийг ажиллуулж байна. Үүнтэй холбоотойгоор угаалгын шингэний сан ашиглах боломжгүй бөгөөд угаалгын циркуляци системгүй, давхаргын усыг ашиглан цооногийг угааж, цооногоос гарсан шингэнийг дахин ашиглахгүй байгаа нь угаалгын шингэнийг бэлтгэх материалын хэмжээ болон өрөмдлөгт зарцуулж байгаа зарцуулалтын хэмжээ босоо цооногтой харьцуулахад маш өндөр байна.

Эдгээр өрөмдлөгийн хүндрэлүүдээс угаалгын шингэний сонголт, төрөл, шинж чанар, урсгалын горимыг нарийн тооцож ашиглах нь урьдчилан сэргийлж болох бөгөөд эсрэгээр нарийн тооцоогүйгээс угаалгын шингэн нь эдгээр

хүндрэлийг үүсгэх нөхцөл болох тал бий. Үүнээс үзэхэд өрөмдлөгийн технологи, цооног нэвтрэлт нь угаалгын шингэний шинж чанар, төрөл, сонголтоос ихээхэн хамаарах нь харагдаж байна.

Иймд далд уурхайн өрөмдлөгийн нөхцлийг үнэлэх, угаалгын шингэний технологийн үзүүлэлтийг нарийн тооцох шаардлагатай байна.

Далд уурхайн өрөмдлөгт алмазан эргэлтэд өрөмдлөгийн аргаар цооногуудыг өрөмдөж байгаа бөгөөд эргэлтийн хурдыг дунджаар 1500эрг/мин, чулуулгийн төрөл, шинж чанар болон цооногийн гүн, үзүүрийн багажийн хатуулгаас хамаарч даралтыг 1000-2500psi хязгаарт тус тус өрөмдөгдөж байна. Далд уурхайн өрөмдлөгт дараах зориулалтын цооногуудыг өрөмдөж байна. Үүнд:

- Чичирхийллийн цооног бол 200-70 метрийн гүнтэй, -75 аас 90 градусын хооронд
- Геотехникийн тандалтын цооногууд ихэвчлэн 200-1000м гүнтэй +20 оос -70 градусын хооронд
- Ашиглалтын цооног буюу уурхайн түвшин хооронд нэвтэлж цахилгааны утас болон ус тунгаагч сампны хуванцар хоолой 2 түвшний хооронд гаргах цооногууд ихэвчлэн 30-80метрийн гүнтэй -65 аас -75 градусын хооронд
- Уурхайн хүдэр буулгах болон түвшин хооронд агааржуулалтын том нүх гаргах зорилгоор өрөмддөг рейзборийн өрөмдлөг
- Чулуулгийн бэхэлгээ хийх зориулалтаар 30-50 метрийн гүнтэй -89 градустай өрөмдлөг

Өрөмдлөгийн технологийн горимууд болох эргэлтийн давтамж, угаалгын шингэний зарцуулалт, тэнхлэгийн ачаалал, механик хурд зэрэг нь эргэлтэд өрөмдлөгийн үед цооног цэвэрлэх угаалгын шингэний төрөл, шинж чанараас ихээхэн хамаарна.

Судалгааны объект болох далд уурхайн өрөмдлөгт угаалгын шингэний технологийн үзүүлэлтүүдийг дараах хязгаарын утганд хэрэглэж байна (Хүснэгт-1).

1-р ХҮСНЭГТ. УГААЛГЫН ШИНГЭНИЙ ТЕХНОЛОГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Угаалгын шингэний үзүүлэлтүүд	Нягт, гр/см ³	Зууралдлага, сек	Хатуу хэсгийн агуулга, %	Ус өгөлтийн хэмжээ, см ³	Бүрхүүлийн зузаан, мм	pH
1	Хэвийн нөхцөлд ашиглах	1.02-1.10	28-40	<4	12-15	2-3	8-10
2	Хүндрэлтэй нөхцөлд ашиглах	1.05-1.20	32-50	<4	14-18	2-3	8-10

Хүснэгтээс үзэхэд ус алдах, дээжийн гарц, үртэс зөөгдөлт муудах зэрэг хүндрэлтэй нөхцөлд угаалгын шингэний технологийн үзүүлэлтүүдийг тухайн чулуулгийн шинж чанарт тохируулан боловсруулалт хийх шаардлагатай болдог.

Далд уурхайн өрөмдлөгийн үед цооногийн зориулалтаас хамааран цооногууд чиглэлтэй буюу хазайлттай, хэвтээ чиглэлээр өрөмдөгдөж байгаа билээ. Үүнтэй уялдан цооногийн ханын тогтворжилт алдагдах, үртэс зөөгдөлт буурах, эргэлт тогтворгүй болох зэрэг хүндрэлүүд үүсэж байгаа нь угаалгын шингэний технологийн шинж чанарт анхаарах шаардлагатайг харуулж байна.

Энэхүү судалгаанд дээрхи өрөмдлөгийн хүндрэлүүдээс үртсийн зөөгдөх чанарыг голлон сонгож, цооног цэвэрлэгээний технологи, угаалгын шингэний төрөл, шинж чанараас хэрхэн хамааралтай байгааг судлахыг зорилоо.


Өрөмдлөгийн нэвтрэлт, хурданд угаалгын шингэний технологийн шинж чанар хэрхэн нөлөөлөл үзүүлэх талаар судалгааны ажлууд байдаг боловч үртэс зөөвөрлөх чанарын талаар судалсан судалгаа байдаг ч өрөмдлөгийн шингэний зууралдах чанар үртэс зөөвөрлөх гүйцэтгэлд ямар нөлөө үзүүлдэгт анхаарч судалсан нь цөөхөн. Түүнчлэн урсгалын нөхцөл байдал ямар байхад өрөмдлөгийн шингэний зууралдлагаас хамаарсан үртэс зөөвөрлөх чанарыг судалсан судалгаа байхгүй байна. Үүнээс үүдэн шингэний зууралдах чанар нь үртэс зөөвөрлөх гүйцэтгэлд яаж нөлөөлдөг тал дээр хэвтээ чиглэлийн, шилжилтийн болон тогтворгүй ширүүн урсгал дээр хийгдсэн судалгаанууд хоорондоо зөрүүтэй байдаг. Ялангуяа цооног өрөмдлөгийн үед хэвтээ болон их хазайлттай/чиглэлтэй цооноогоор үртэс зөөгдөхөд реологийн шинж чанар, өрөмдлөгийн угаалгын шингэний зууралдлага, эргэлтийн хурд болон цооногийн өнцөг ямар нөлөө үзүүлж байгааг судлах нь чухал байна.

Өрөмдлөгийн цооногийн тэнхлэг босоо чиглэлээс өөрчлөгдөж хэвтээ, хазайлттай өрөмдөх үед чулуулгийн үртсийн зөөгдөлт муудаж, цооногийн доод хэсэгт хуримтлагдах нөхцлийг бүрдүүлдэг. Үүнтэй холбоотойгоор цооногт ажиллаж байгаа яндан хэт чангарах, чирэгдэх болон эргэлт тогтвортой байдлаа алдах, үртэс зөөгдөхгүй тунах зэрэг хүндрэлүүд үүсдэг байна.

Өрөмдлөгийн шингэний үртэс зөөвөрлөх чадвар нь цооног цэвэрлэгээний чанарын гүйцэтгэлийг тодорхойлох бөгөөд цооног цэвэрлэх ажиллагаа хангалттай хийгдэж байж л дээр дурьдсан хүндрэлүүд үүсэхээс сэргийлж чадна. Улмаар өрөмдлөгийн цаг бага шаардагдах ба энэ нь өрөмдлөгийн зардлыг үлэмж хэмжээгээр бууруулах болно.

Зураг-2 -оос үзэхэд цооногийн хазайлтын өнцгийг үл ялиг өөрчлөхөд угаалгын шингэний

өргөх хүчинд нөлөөлнө. Өрөмдлөгийг босоогоос хэвтээ чиглэлд шилжүүлэхэд өрөмдлөгийн шингэний үртэс зөөвөрлөх хүчин чадал буурах болно. Энэ нь үртэс дээшээ өргөгдөх гэхээсээ илүү цагирган хэлбэртэй биетийн хажуугийн ханыг дагаж доошоо унах хандлагаас болж үүсдэг байна.



2-р зураг. Цооногийн өнцгөөс үртэс зөөгдөлт хамаарах байдал

Оюу толгойн далд уурхайн өрөмдлөгийн үед Зураг-2 дахь P4, P5 өнцгийн хазайлттай өрөмдөгдөж байгаа геотехникийн цооногуудын өрөмдлөгийн үеийн үртэс гаргалтын хэмжээ, P1, P2 өнцгийн хазайлттай өрөмдөгдөж байгаа тандалтын цооногуудын өрөмдлөгийн үртэс гаргалттай харьцуулахад муу байна. Энэ нь цооногийн өнцгийг 60-аас 90 градус болгож системтэйгээр нэмэгдүүлэхэд үртэс зөөвөрлөх гүйцэтгэлд эергээр нөлөөлдөг буюу 40 хүртэл хувиар нэмэгддэг нь тогтоогдсон байна. Түүнчлэн өрөмдлөгийн шингэний эргэлтийн хурд нь үртэс зөөвөрлөх гүйцэтгэлд маш чухал нөлөө үзүүлдэг нь харагдсан байна.

Далд уурхайн өрөмдлөгийн үед үүсэх технологийн хүндрэлүүдээс урьдчилан сэргийлэх, үүссэн хүндрэлийг арилгахад угаалгын шингэний технологийн үзүүлэлтүүдээс угаалгын шингэний урсгалын хурд, уусмалын зууралдлага, урсгалын горимыг голчлон үзэх шаардлагатай гэж үзэж байна.

Далд уурхайн өрөмдлөгийн үед чулуулаг тогтвортой өрөмдлөг хэвийн явагдаж байгаа үед CR-650, PAC-R, Superlube зэрэг уусмалын төрлүүдийг хэрэглэдэг ба тогтворгүй шаварлаг зөөлөн чулуулгийн үе болон хагарал ихтэй, хайрга чулуулгийн үе давхаргад ханыг тогтворжуулах, ан цавыг хаах зорилгоор их хэмжээгээр Aus-Gel болон Ezee-Trol хэрэглэдэг. Угаалгын шингэний зарцуулалтыг хэвийн нөхцөлд чулуулаг болон үзүүрийн багажийн хатуулгаас хамаараад 50-70л/мин, хэт хатуу чулуулагт 30-40л/мин, тогтворгүй нурулт ихтэй чулуулгийн үед нурах магадлалтай байдаг тул зарцуулалтыг 30-40л/мин болгон багасгадаг.

Туршилтыг 200-1000м гүнтэй +20 оос -70 градусын хооронд явагдах геотехникийн цооногийн өрөмдлөг дээр явуулсан бөгөөд CR-650, PAC-R, Superlube төрлийн угаалгын шингэний төрлүүдийг ашиглаж, угаалгын шингэнээр зөөгдөн гарсан үртсийн хэмжээг хатаан жигнэж харьцуулан, үртэс гаргалтын хэмжээг тодорхойлсон болно. Тухайн үеийн угаалгын шингэний технологийн үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэд үзүүлэв.


2-Р ХҮСНЭГТ. УГААЛГЫН ШИНГЭНИЙ ТЕХНОЛОГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нөхцөл	Нягт, гр/см ³	Зууралдлага, сек	Хатуу хэсгийн агуулга, %	Ус өгөлтийн хэмжээ, см ³	Бүрхүүлийн зузаан, мм	pH	Үртсийн хэмжээ, кг
Хэмжилт-1	1.02	32	<4	14	2	8	8
Хэмжилт-2	1.15	42	<4	14	2	8	13
Хэмжилт-3	1.20	48	<4	14	2	8	11

Өрөмдлөгийн үед цооног өрөмдлөгийн үртэс гаргалт муудсан тул угаалгын шингэний зууралдлагыг 1.02 гр/см³ -аас 1.15 гр/см³ болон 48 сек, зууралдлагыг 32 сек-ээс 42, 48 сек-ийн зууралдлагатай болгож өөрчлөн 3 удаагийн хэмжилтийг явуулав. Хэмжилтийг явуулахдаа нэг төрлийн чулуулгийн үед явуулсан бөгөөд 1 рейсийн хугацаанд буюу 3м өрөмдөх хугацаанд зөөгдөн гарч ирсэн чулуулгийн үртсийг хатаан, хэмжин тодорхойлон гаргасан болно. Үртэс гаргалтын хэмжээний өөрчлөлтийг дараах зургаар харуулав.

3-Р ХҮСНЭГТ. ЗУУРАЛДЛАГААС ХАМААРСАН ҮРТЭС ГАРГАЛТЫН ХЭМЖЭЭНИЙ ХАРЬЦУУЛАЛТ

Угаалгын шингэний зууралдлага, сек		
32 сек	42сек	48сек
Үртэс гаргалтын хэмжээ, кг		
8кг	13кг	11



3-р зураг. Зууралдлагаас үртэс зөөгдөлтийн хэмжээ хамаарах байдал

Судалгаанаас харахад угаалгын шингэний зууралдлагыг нэмэгдүүлэхэд үртэс гаргалтын хэмжээ мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдэж байна. Энэ нь хэмжилт-1, хэмжилт-2-ын үр дүнд харагдаж байна. Харин зууралдлагыг дахин нэмэгдүүлэхэд эсрэг нөлөө үзүүлж байгаа нь хэмжилт-3-ын үр дүнгээс харагдаж байна.

Үртсийг өндөр хазайлттай цооногоор тээвэрлэж байгаа үед зууралдлага яаж нөлөөлдөг талаар олон янзын санааг судлаачид дэвшүүлсэн. Zeidler (1972), Okrajni болон Azar (1986), Pilehvari et al. (1999), Jawad (2002), Kelessidis et al. (2007), Mohammadsalehi болон Malekzadeh (2011) зэрэг зарим судлаачид өрөмдлөгийн угаалгын шингэний зууралдлагыг нэмэгдүүлэх нь цооногийн цэвэрлэгээг дордуулдаг гэж үзсэн бөгөөд үүнийг угаалгын шингэний урсгалын горим нь турбулент горимоос ламинар горимд шилжсэнээр тайлбарласан байна.

Шингэний гидравликийн хувьд шингэний урсгалын 2 горим байдаг гэж үздэг байна.

- Ламинар горим-шингэний тогтвортой урсгал. Энэ нь тодорхой голчтой хоолойгоор урсах шингэний хэсгүүд хоолойн тэнхлэгтэй параллель буюу шулуун чиглэлээр ямар ч хөндлөн шилжилт хийхгүй, нэг төвтэй цагираг үе дээр урсах шингэнийг хэлнэ.

- Турбулент горим-шингэний тогтворгүй урсгал. Энэ нь шингэний хэсгүүд хурд ба даралтын лугшилтын нөлөөгөөр эрчимтэй холилдож эмх замбараагүй урсах шингэнийг хэлнэ.

Урсгалын хурд ба хөндлөн огтлолын хэмжээ ихсэх, уусмалын зууралдлага ихсэх багасах нөхцөлд шингэний нэг горимоос нөгөө горимд шилжих боломжтой байдаг байна.

Английн эрдэмтэн Рейнольдс урсгалын шинж чанар нь Re гэх нэгжгүй хэмжигдэхүүнээс хамаарна гэж үзсэн бөгөөд Рейнольдсын тоо нь дараахаар тодорхойлогдоно.

Гидравликийн радиусаар илэрхийлбэл:

$$Re = \frac{U \cdot R \cdot \rho}{\mu} = \frac{U \cdot R}{\mu} \quad (1)$$

Дугуй огтлолтой хоолойн голчоор илэрхийлбэл:

$$Re = \frac{U \cdot d \cdot \rho}{\mu} = \frac{U \cdot d}{\mu} \quad (2)$$

Үүнд: Re – Рейнольдсын тоо, ρ – шингэний нягт, U – шингэний дундаж хурд, μ – шингэний зууралдлага

Практик тооцоонд шингэний хөдөлгөөний горимыг тогтооход гидродинамикийн төсөөтэй онолыг ашиглан хэмжих нэгжид анализ хийх арга дээр үндэслэн Рейнольдсын тоог гарган тодорхойлж болно.

Тодорхой чиглэл, өнцгийн хазайлттай цооног өрөмдлөгийн үед чулуулгийн үртэс нь ламинар горимоос илүү турбулент горимын үед илүү сайн зөөгдөх магадлалтай гэж үздэг байна.

Хүснэгт 3-аас үзэхэд цооногийн өнцгөөс үл хамааран үндсэн зууралдлагыг 32сек-оос 42 сек болгож нэмэгдүүлэхэд үртэс зөөвөрлөх гүйцэтгэл нэмэгддэг гэдэг нь тодорхой харагдаж байна. Гэсэн хэдий ч зууралдлагыг 48 сек болгож эрчимжүүлэхэд үртэс зөөгдөлд сөргөөр нөлөөлж байна гэж үзэв.

Зууралдах чанарыг нөлөөлөх нөгөө 2 параметр болох шингэний эргэлтийн хурд, цооногийн өнцгийн хамт янз бүрийн урсгалын нөхцөлд шалгаж үзсэн.

- Урсгалын горим тогтворгүй ширүүн байлгаад эргэлтийн хурдыг тогтмол байлгахад бүх өнцөг дээр өрөмдлөгийн шингэний зууралдлагыг нэмэгдүүлэхэд үртэс зөөвөрлөх гүйцэтгэл ойролцоогоор 8%-иар сайжирсан.
- Гэхдээ урсгалыг горимыг завсрын юмуу хавтгай гадаргуу дээр урсах горимонд шилжүүлэн зууралдах чанарыг үргэлжлүүлэн нэмэгдүүлэхэд үртэс зөөвөрлөх гүйцэтгэлийн дунджаар 12%-иар буурсан гэж туршилтаар тогтоогдсон байна.

Туршилтын өгөгдлөөр урсгалын хурд болон шингэний урсгалын горимыг тооцож үзвэл:

Цооногт 50л/мин зарцуулалттай шахагдаж байгаа шингэний урсгалын хурдыг тооцвол:

$$NQ = \frac{1270 \cdot 50}{(96 \cdot 96) - (89 \cdot 89)} = 49.03 \text{ м/мин} = 0.81 \text{ м/сек}$$

$$NQ = \frac{1270 \cdot 50}{(75.7 \cdot 75.7) - (69.9 \cdot 69.9)} = 75.19 \text{ м/мин} = 1.25 \text{ м/сек}$$

Рейнольдсын тоог тодорхойлбол:

$$Re = \frac{U \cdot D \cdot \rho}{\mu} \quad (3)$$

Туршилтанд ашигласан уусмалын нягтын өөр утганд HQ голчоор өрөмдөх үед:

$$1.02 \text{ кг/м}^3 \text{ буюу } 1020 \text{ гр/см}^3 \text{ нягттай үед:}$$

$$Re = \frac{0.81 \cdot 0.096 \cdot 1020}{20 \cdot 10^{-3}} = 3965$$

1.15 кг/м^3 буюу 1150 гр/см^3 нягттай үед:

$$Re = \frac{0.81 \cdot 0.096 \cdot 1150}{22 \cdot 10^{-3}} = 4064$$

1.20 кг/м^3 буюу 1200 гр/см^3 нягттай үед:

$$Re = \frac{0.81 \cdot 0.096 \cdot 1200}{23 \cdot 10^{-3}} = 4057$$

Туршилтанд ашигласан уусмалын нягтын өөр утганд NQ голчоор өрөмдөх үед:

$$1.02 \text{ кг/м}^3 \text{ буюу } 1020 \text{ гр/см}^3 \text{ нягттай үед:}$$

$$Re = \frac{1.25 \cdot 0.075 \cdot 1020}{20 \cdot 10^{-3}} = 4781$$

1.15 кг/м^3 буюу 1150 гр/см^3 нягттай үед:

$$Re = \frac{1.25 \cdot 0.075 \cdot 1150}{22 \cdot 10^{-3}} = 4900$$

1.20 кг/м^3 буюу 1200 гр/см^3 нягттай үед:

$$Re = \frac{1.25 \cdot 0.075 \cdot 1200}{23 \cdot 10^{-3}} = 4891$$

Шингэний урсгалын Рейнольдсын тоо < 2300 хязгаарт шингэний урсгал ламинар горимоор, харин Рейнольдсын тоо $4000 <$ хязгаарт турбулент горимоор урсана. Үүний дагуу шингэний урсгалын хурд, цооногийн голч, шингэний нягтаас хамаарсан хамаарлаар уусмалын нягт байх нөхцөлд цооног дахь шингэний урсгал ламинар горимоор, харин уусмалын нягтыг ихэсгэхэд турбулент горимд шилжсэнээр үртсийн зөөгдөх чанар илүү сайжирсан гэж дүгнэж байна. Харин уусмалын нягт болон зууралдлага илүү өсөхөд урвуу хамааралтай, өөрөөр хэлбэл үртэс зөөгдөл муудах талтай байна. Туршилтын үр дүнгээс үзэхэд мөн тодорхой цооногийн хазайлттай нөхцөлд цооногийн ханын тогтворжилт болон үртсийн тунах хурдын нарийн тооцох шаардлагатай нь харагдаж байна.

Ижил урсгалын түвшинд угаалгын шингэний зууралдлагыг нэмэгдүүлснээр одоогийн урсгалын горим нь турбулент урсгалаас хэвтээ чиглэлийн урсгал руу хөрвөх хандлагатай байдаг.

ДҮГНЭЛТ

Далд уурхайн өрөмдлөгт угаалгын шингэний технологийн шинж чанар ямар нөлөөлөл үзүүлж байгааг уг судалгаагаар хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Босоо цооног өрөмдлөгийн технологи үйл ажиллагааг далд уурхайн өрөмдлөгийн технологитой харьцуулан онцлогийг гаргав.

Далд уурхайн өрөмдлөгийн үед технологи ижил боловч зарим өрөмдлөгийн нөхцлөөс хамааран тодорхой технологийн хүндрэлүүд үүсдэг байна.

Угаалгын шингэний зууралдах чанар үртэс зөөвөрлөлтөнд нөлөөлдөг талаар өмнөх хийгдсэн судалгаанууд дээр олон няцаалт, маргаан байдаг тул энэхүү судалгааны ажлын зорилго зууралдлагын нөлөөн дээр илүү төвлөрч хийсэн. Судалгааны зорилготой нийцүүлэн нөлөөлдөг бүх хүчин зүйлүүдээс цооногийн хазайлт, угаалгын шингэний зууралдлага, эргэлтийн хурд гэсэн гурван зүйлийг сонгон авсан. Энэхүү судалгааны ажлын гол үр дүнг доорх байдлаар дүгнэв:

1. Тодорхой хазайлттай цооног өрөмдлөгийн үед цооногийн хазайлтаас шалтгаалан үртсийн зөөгдөх чанар муудаж байна
2. Судалгаанаас үзэхэд угаалгын шингэний зууралдлагыг нэмэгдүүлэхэд үртсийн зөөгдөх чанар мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгддэг, зууралдлагын хэмжээ нэмэгдэх нь үр дүнд урвуугаар нөлөөлж байна. Эргэлтийн хурд болон цооногийн өнцөг тогтмол байхад зууралдлагыг нэмэгдүүлэх замаар үртэс зөөвөрлөх үзүүлэлт ойролцоогоор бүх өнцөгт 8%-иар нэмэгддэг нь ажиглагдаж байна. Энэ нь зууралдлагаас хамаарсан шингэний урсгалын горимоор тайлбарлаж байна.
3. Тодорхой хазайлттай цооног өрөмдлөгийн үед шингэний урсгалын ламинар горимоос турбулент горимоор угаах нь үртэс зөөгдөлтөнд тохиромжтой гэдгийг тогтоолоо.

НОМ ЗҮЙ

- [1] Ali Piroozian, Issham Ismail, Zulkefli Yaacob, Parham Babakhani, Ahmad Shamsul Izwan Ismail "Impact of drilling fluid viscosity, velocity and hole inclination on cuttings transport in horizontal and highly deviated wells" Journal of Petroleum Exploration and Production Technology volume 2, pages149–156 (2012).
- [2] Л.Төвхөө, Өрөмдлөгийн процессын мэдээлэл боловсруулалт, загварчлал, оновчлол. Улаанбаатар, 2009 он
